

Mongolian Buddhism in Practice

2nd International Conference on Mongolian Buddhism

April 24–25, 2017, Budapest

Abstracts



Eötvös Loránd University, Faculty of Humanities

Department of Mongol and Inner Asian Studies

Research Centre for Mongol Studies

Budapest Centre for Buddhist Studies

Hungarian Academy of Sciences

Research Centre for the Humanities, Institute of Ethnology

Embassy of Mongolia in Hungary

Returning Lamas: Life After the Monastery

Saskia ABRAHMS-KAVUNENKO

Max Planck Institute for Social Anthropology,
Research Group 'Buddhist Temple Economies in Urban Asia', Germany

Many young Mongolian lamas and nuns spend around ten years studying full time in monasteries in India. These studies are characterized by strict discipline and training in monastic residential complexes. After returning home from India, many struggle to readjust to life in Mongolia. Most have difficulties meeting the expectations of family and life in a fast paced and radically changing city. The majority of lamas are unable to live residentially within Mongolian temples and must support themselves financially. This paper will explore the experiences of the Mongolian sangha after they return to Ulaanbaatar. It will look at the economic and social pressures that most face when they return home and how they negotiate life after India.

Rendering Sanskrit and Tibetan in the Mongolian Kanjur – A Preliminary Report

Kirill ALEKSEEV

St. Petersburg State University, Faculty of Asian and African Studies,
Department of Tibetan and Mongolian Studies, Russia

The new ascent of translation activity and the re-working of old translations of Buddhist works in late 16th century Mongolia demanded solving questions of transcription, including of Indian and Tibetan words.

According to Mongolian historiographical tradition this task was solved by one of the eminent translators of Buddhist literature Ayusi güsi, who was active in Eastern Mongolia in the late 16th and early 17th centuries. He compiled his transcriptionary alphabet in 1587, at the behest of the Third Dalai Lama, and following the example of the Tibetan rendition of the "fifty Indian letters".

Mongolian literature is abundant in works explaining the system and the principles of the *Āli-kāli* alphabet. Nevertheless, almost all of these texts are of a prescriptive character and do not tell us much about how the system actually worked in Mongolian translations.

The Mongolian Kanjur is a large and diverse corpus of Buddhist texts, translated from various languages over a large span of time (from the late 13th to the early 18th century) and, therefore, a valuable source of information on rendering Sanskrit and Tibetan in Mongolian script.

Recent work on the *Comparative Catalogue of the Golden Kanjur* allowed us to compare different copies of the manuscript edition carried out in the years 1628–1629 under Ligdan Khan of Chakhar and the blockprint created under the auspices of the Emperor Kangxi in 1718–1720 in Beijing.

The results of the collation show that the Golden Kanjur, the earliest copy of the Ligdan's manuscript edition written down in 1629, contains texts that belong to the different periods and schools of Mongolian translation activity. Thus, the ways of rendering Sanskrit and Tibetan words in the Golden Kanjur vary from the total absence of *Āli-kāli* letters to the elaborate use of the transcriptionary signs, including those rarely found by in the later copies. Though the consequent "black" manuscript copies reveal more uniformity in rendering foreign words, it is still hard to speak of some precise and common system for rendering Sanskrit and Tibetan. Such a system appears only in the blockprint edition of the Mongolian Kanjur in the early 18th century.

"Сайшаалтай ерөөлт эрхшилийн эзэн хааны сан тахил эгээрлийг хангагч хэмээгдэх оршив" хэмээх судрын тухай

Л. АЛТАНЗАЯА

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Монгол улс

XVII-XVIII зууны үеийн Монгол дахь бурханы шашны түүхэнд холбогдох олон сурвалж хэрэглэгдэхүүн байдгийг эрдэмтэн судлаачид тал бүрээс нь судлан шинжилсэн байдаг. Бид тэдгээр судар номуудын нэг болох "Сайшаалт ерөөлт эрхшилийн эзэн хааны сан тахил эгээрлийг хангагч хэмээгдэх оршив" хэмээх судрын тухай танилцуулахыг хичээнэ. Монгол улсын үндэсний төв архивт хадгалагдаж буй монгол бичгийн зарим баримтад Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хааныг "Дэлхий дахины эзэн Манзушир Богд хаан", "Манзушир их богд эзэн" хэмээн бичсэн байдаг бөгөөд "Манзушир бурханы хувилгаан бие эзэн хаан"-д сан тахил өргөх ёсыг дурдан Нанзаддорж хэмээгчийн бичсэн уг судрыг сэдэвт холбогдох зарим хэрэглэгдэхүүнтэй уялдуулан судлах нь тухайн цаг үеийн бурханы шашны зан үйлийн хэлбэр, хамрах хүрээ хэвчээнд гарч байсан өөрчлөлтийн бодит байдлыг тодруулахад зохих ач холбогдолтой болов уу. Уг судар бичмэлээр тархсан бөгөөд түүний нийтлэг болон онцлог шинжийг судлан тодруулахыг оролдсон болно.

Two Hambo Lamas – Symbolic Persons of Buddhist Revival in Buryatia

Darima AMOGOLONOVA

Department of Philosophy, Cultural Studies and Religions,
Institute for Mongolian, Buddhist and Tibetan Studies,
Siberian Branch, Russian Academy of Sciences, Russia

Religious revival is seemingly the most convincing evidence of the political and ideological transformations in the Russian society. Simultaneously, returning religion only partly relates to worldview change: in reality, it has occupied the principal position in the post Soviet ethnic renaissance, which embraced all the ethnic groups in Russia. Nowadays, Buddhism remains the only sphere, in which Buryat ethnicism can manifest itself in both religious and secular aspects including protection of Buryat culture especially ethnic language and support to the traditional way of economy (sheep and horse breeding) as well as holding Buryat youth in the villages.

Successful realization of these tasks was undertaken by Hambo Lama Ayusheev enthroned in 1995. To strengthen Buddhist influence on the 'hypothetic' believers, he has resorted to the unmistakable proof that witnesses for the topicality of Buddhist spirituality in the conditions when a rationalized mind needs evidence of the advantages of the religious tradition. In this sense, the glorious Return of the Hambo Lama Itigelov's 'Imperishable Body' (at present renamed to the 'Precious and Unquenchable Body' that better corresponds to the essence of the phenomenon and emphasizes its uniqueness) was that symbolic event, which essentially strengthened the positions of Buddhism among Buryats and contributed to its importance in Russia and worldwide. Thus, both Hambo Lamas – Itigelov and Ayusheev – are the symbolic persons of Buddhist revival in Buryatia and the evidence of irreversibility of the changes taking place in the spiritual sphere.

Модель человека в буддизме: экономический аспект

Д. Н. БАДГАЕВА

Московский Государственный Университет, Россия

Один из ключевых вопросов, который я хотела бы затронуть в данном докладе, — это экономический аспект модели человека в буддизме. Границы экономического анализа модели человека в буддизме остаются неопределенными. Насколько релевантна модель западного «экономического человека» для людей, живущих в другом экономическом социуме, например, жителей буддийских регионов России, например для современных калмыков, в прошлом степных кочевников? Действительно ли существуют противоречия между религиозными (буддийскими) ценностями и экономическим прогрессом?

Вопрос о влиянии буддизма на экономическое развитие одним из первых поставил немецкий социолог М. Вебер [1990], выдвинув тезис об иррационализме буддизма и о несовместимости ценностей этой религии с развитием капиталистической экономики. Следует ли из этого вывод, что буддийской экономике чужда и модель экономического человека, основанная на этих ценностях? Я не согласна с мнением М. Вебера, что буддизм иррационален. Модель человека здесь тоже рациональна, но эта рациональность имеет свою специфику.

В работах немногочисленных авторов по обсуждаемой нами теме (С.-К. Колм, Л. Жолнаи и др.) буддизм представлен как особый вид экономической философии или социологии. Известный французский экономист Серж Кристоф Колм придает большое значение приоритету социальных услуг как «этической парадигмы экономики» [Kolm 1983]. Именно экологический и человеческий облик буддийской экономики подчеркивает в своей работе современный венгерский экономист Ласло Жолнаи [Zsolnai 2009]. Я с ними полностью согласна и постараюсь показать это в своем докладе.

На мой взгляд, в буддизме можно обнаружить ту нить, которая связывает мотивацию действий человека, в т. ч. экономических, доступные ему знания и способности (главным образом интеллектуальные) практически с любой сферой современной жизни. В буддийской мотивации экономического поведения явно налицо воздействие других мотивов, кроме стремления к богатству. В трактовке мотивационного компонента модели человека помимо таких традиционных целей, как благосостояние, полезность, удовлетворение потребностей я бы добавила функцию творческую, когнитивную: это тренировка ума, желание самореализации, стремление к совершенству.

The Historical Significance of the Buddhist Temple in Saint-Petersburg

Buda BADMAEV – Inna VASILEVA

St. Petersburg Datsan, Russia

In 2015 the 100th anniversary of the Buddhist Temple Gunzechoinei (ཀུན་བཟེ་ཆོས་གནས་བླ་མ་ཆོང་) in St. Petersburg, the capital of the former Russian Empire, was widely celebrated in Russia not only by Buddhists but also by wider cultural circles. This is a landmark of the extreme northward spread of the Dharma in the pre-modern times (60° N) and a unique historical and religious building.

Several Mongolian peoples who were Tibetan Buddhists became Russian subjects as early as in the 17th century. While Europeans were banned from entering Tibet, Russian subjects of Mongol stock visited it rather freely. In the late 19th century

Agvang Dorjiyev (འག་དབང་རྡོ་རྗེ་ཡབ་; 1853/54–1938), a learned lama from Russia, became a teacher (མཚན་ཞབས་མཁན་པོ་) of the Thirteenth Dalai Lama.

In 1908 Dorjiyev presented to the Russian Foreign Ministry the Dalai Lama's request to build a Buddhist temple in the capital of Russia. The building of the Temple was approved by the Czar Nicholas II and started in 1909. It was finished in August 1915.

The temple is a unique example of Tibetan-European style: it is shaped as a Tibetan temple (quadrangle shape, the building narrows towards the top) with some typical features of a European temple (columns with bronze capitals, large steps leading up to the main entrance).

Though religion was greatly oppressed in the 1920s and 1930s, Dorjiyev managed to secure diplomatic immunity for the Temple, which was turned into a "Tibetan-Mongolian Mission." The temple was closed in the late 1930s and was only handed over to believers in 1990.

Officially the Datsan in Saint Petersburg is a branch of the Ivolginskii Datsan (འག་འཕྲུག་བླ་མ་གྱིས་ཚུགས་འཁོར་གྱི་ཁྱེད་) in Eastern Siberia – the residence of the Head Lama (མཁན་པོ་ལྷ་མ་) of the Traditional Sangha of Russia.

The present-day Datsan is an important Buddhist and cultural centre of Russia. Its lamas, besides performing religious rituals, give lectures on Buddhism, help sick people by means of Tibetan medicine, and participate in scholarly conferences

Этигэлэй Хамба лама

Ширээт лам Балдан БАЗАРОВ

Буриадын Тункэн дацан, ОХУ

2002 онд тахиа сарын шинийн 4, Хүхэ Зүрхэн гэдэг газраас 12 дугаар Бандида Хамба Ламын бие Ивалгын дасанд залаж авч ирсэн байгаа. 1927 онд 75 нас сүүдэртэй Этигэлэй Хамба Лам мүнх бус үзүүлсний дараа 75 жил Хүхэ Зүрхэн газарт хадгалагдаж байсан байгаа. Энэ залалгын ажилгаанд судмедэксперт оролцож гадны талаас харж үзсэний дараа дүгнэлт гаргасан байна. Энэ хүний биеийн байдал амьд хүний биетэй яг адил байна. Энэ үеэс одоо хүртэл 15 жил өнгөрөв. Этигэлэй Хамба Ламын бие зөв зүгээр Ивалгын дацанд саатаж байгаа. Их хуралнуудын үед олон сүсэгтэн мургэшүүл ирж Эрдэни биенээс нь адис хүртэж байхад биеийн дулаан 33–34, 36–37 градус болдог, биенээс нь хөлс гардаг байна. Бусад өдрүүдэд биеийн дулаан 18–23 градустай.

Хүмүүст түүний бие өөр өөрөөр харагддаг. Жишээ нь надад хааяа-хааяа зүн нүдээрээ хараад байна (ширтэнэ) гэж харагддаг, өөр хүмүүс баруун эсвэл зүн нүдөөр харна гэдэг. Ном уншиж сууна, сонин сэтгүүл гартаа бариад байна гэдэг. Нүдний өнгө нь азийн гаралтай хүмүүс бор эсвэл хар гэж хардаг. Европын хүмүүс хөх сэнхэр Этигэлтэй Хамба Лам хоёр нүдээрээ хараад суусан. Би анх удаа хараж байгаа болхоор, дандаа ийм байдалтай гэж бодсон. Тэгэхдээ надад анивгад гэсэн шүү. Би сочиж авсан.

2011 оноос эхлээд одоо хүртэл Этигэлэй Хамба Лам өдөр бүр сургааль айлдаад байгаа. Энэ сургаалыг нь Бимба лама хүлээн аван өдөр бүр 24 дугаар Бандида Хамба Лам Аюшын Дамбад хүргэж өгдөг. Манай одоогийн Хамба Лам тайлбар хийж фэйсбүүк дээр табирахад нь олон түмэн хүмүүс олж харах аргатай байна. Энэ сургаалуудтай нь танилцуулъя.

2016.08.05. Этигэл Хамба Ламын сургаал. Этигэл Хамба Лам эшхэрэнди хонхын авиа дуулаад (сонсоод): “Сагай хүрдэн эргэхэ холбоо”-гэж айлдаа.

2016.08.14 Этигэл Хамба Ламын сургаал. Нэгэ хүн нөгөө хүүнд: “Утга ынь буруу ойлгохо аад, юундэ сээжэлдэнэш” гэнэ. Этигэл Хамба лам: “Балар аараг хоёр ухаанаа тэг шэрүүлхэ гүн ухаан” – гэж айлдаа.

2016.09.08. Этигэл Хамба Ламын сургаал. Нэгэ эрэ хүн: “Юртэмсэ оршолон гэжэ байгалийн мэдэлэй юм байна” – гэхэд нь. Этигэл Хамба Лам: “Хүний ухаан эхи заха үгэй, саг хэмжүүр үгүй, зай забсар үгүй” – гэж айлдаа.

2016.09.24. Этигэл Хамба Ламын сургаал. Ленин Сталин хоёрын нас барсан цаг харагдаад, агаараар дүүрэн алтан тоос ялалзажа байна. Этигэл Хамба Лама: “Талада ябахадаа ухаангуй ехэ адис абанаш” гэжэ айлдаа.

2016.10.04. Этигэл Хамба Ламын сургаал. Хажуудаа үхэртэй хүгшэн эхэнэр ехэ галай эргэдэ даллага тараажа байгаад- “Абагты! Абагты! Абагты!” – гэхэдэнь, үхэрэнь дохио үгэжэ ехээр мөөрөнө. Этигэл Хамба Лама: “Буряад орон Юлжаан” – гэжэ айлдаа.

Lamyn Gegeen's Advice on Buddhist Text Recitation to Repel Illness

Agata BAREJA-STARZYŃSKA

Faculty of Oriental Studies, University of Warsaw, Poland

Lamyn Gegeen or Khanchin Choijal – mkhan chen chos rgyal Blo bzang bstan 'dzin rgyal mtshan (1639–1704) was one of the most important Buddhist figures in the history of dissemination of Tibetan Buddhism in Mongolia in the 17th century. Educated in Tibet Lamyn Gegeen brought the theory and practice of Tibetan medicine and divination to his homeland. One of his works is a treatise on prognostication entitled *'Bras rtsis legs bshad kun 'dus*, i.e. “Collection of Writings on Prognostication” composed in 1689. The Tibetan version, popular in the past, was translated into Modern Mongolian by Prof. Terbish as *Üriin zurkhai sain*

nomlol бүхний khuraangui (published in 1991 and 2004). Since then it has been used by present-day Mongols. One section of Lamyn Gegeen's work is devoted to Buddhist text recitation to repel illness. The paper examines briefly this part of the work focusing on the Buddhist texts mentioned in it.

The Prostration Helps Healthy Life

Ch. BATNAIRAMDAL, B. NYAMJAV

Mongolian National University of Medical Science,
International School of Mongolian Medicine, Mongolia

Goal: To do analysis on some issues about treatment for constipation using non-drug method

Hypothesis: There is a probability that people who do pilgrimage have higher muscle development compared to people who do normal exercise and movement.

Methods: Total 60 people have been involved from June 2015 until September 2015 and total 50 people have been involved after this. People aged more than 20 years old, not pregnant, having constipation symptom, with 1 or 2nd class of overweight, without any disorder of supporting organs were divided into 2 groups and 25 participated who do pilgrimage or yoga exercise. Also, 10 people were involved in control group. According to the questionnaire, they haven't got light constipation and do permanent exercises and movement. All participants were measured by anthropometry and their electrolyte volume in the blood of vein was defined.

Result: We have noticed during the research that the person with constipation symptom started evacuating 97.8±3.7 minutes after he/she drank water & did pilgrimage and 100.6±6.3 minutes after he/she did yoga exercise.

Body weight index of people with constipation symptom was 30.64 kg/m² before their pilgrimage, was 25.23 kg/m² after their pilgrimage and was 31.17 kg/m² before their pilgrimage and was 28.81 kg/m² after their yoga exercise.

For electrolyte volume in blood of the participants in the research before their pilgrimage, Ca was 1,58 mmol/L, Mg was 1,24 mmol/L, Na was 113,52 mmol/L, Cl was 73,8 mmol/L in average, Ca was 1,24 mmol/L, Mg was 0,91 mmol/L, Na was 102,18 mmol/L, Cl was 61,3 mmol/L after three days, Ca was 1,37 mmol/L, Mg was 1,17 mmol/L, Na was 109,8 mmol/L, Cl was 68,3 mmol/L at the last day of the research.

For electrolyte volume in blood of the participants in the research before their yoga exercise, Ca was 1,63 mmol/L, Mg was 1,20 mmol/L, Na was 121,8 mmol/L, Cl was 68,3 mmol/L in average, Ca was 1,49 mmol/L, Mg was 0,98 mmol/L, Na was 113,1 mmol/L, Cl was 57,8 mmol/L after three days and Ca was 1,53 mmol/L, Mg was 1,0 mmol/L, Na was 115,8 mmol/L, Cl was 60,3 mmol/L at the last day of the research.

Conclusion: It has been determined that less movement is an influencing factor for constipation. The research shows that treatment is effective because body weight index and electrolyte balance is becoming stable after the stretch and pilgrimage.

Святыни Лхасы: по материалам перевода намтара «Жизнеописание Цзонхавы»

Э. П. БАТЫРЕВА
С. Г. БАТЫРЕВА

Калмыцкий Государственный Университет, Россия
Музей Традиционной Культуры имени Зая-пандиты,
Калмыцкий Институт Гуманитарных Исследований,
Российская Академия Наук, Россия

В статье приводятся сведения о религиозно-философских сочинениях буддизма, среди которых особое место занимает жанр жизнеописаний, известных в Тибете и Монголии под общим названием «намтары». К сочинениям агиографической литературы относится жизнеописание владыки Цзонхавы. Перевод двух текстов, тибетского и монгольского, дает возможность получения достоверной научной информации не только об истории буддизма Тибета, оказавшего большое влияние на формирование буддийской художественной культуры и искусства монголоязычных народов: монголов, бурятов и калмыков.

В сочинении «Жизнеописание Цзонхавы», помимо приведения подробных сведений о биографии Цзонхавы, основоположника желтошапочного направления Гелуг в северном буддизме, приводится множество данных о строительстве храмов, ступ и культовой скульптуры, украшавшей храмовое строительство в Тибете. Их строилось множество в Лхасе, столице государства. Так, например, рассказывается, как были установлены статуи Будды, известные как Великий Чжу и Малый Чжу в Лхасе. Описание сопровождается подробностями о времени, месте и драгоценных деталях создания произведений искусства. Они становятся легендарными святынями не только Тибета, но и всего буддийского мира монгольских народов. Информация об архитектурных сооружениях, в том числе и о монастыре Галдан, основанном Цзонхавою в 1409 году *на горе Брэг-ри (Уединённая гора)*. Интересны свидетельства о материале и технике изготовления буддийской скульптуры, изготавливавшейся из благородного металла в технике замещенного воска. Все

это дает основание составить представление о практике культового строительства в полном объеме. Последнее становится образцом создания национальной художественной школы Монголии, оказавшей несомненное влияние на формирование искусства ойратов и калмыков, других монголоязычных народов. Созерцание культовых объектов используется в практике поклонения иконографическому образу, отвечающему всем требованиям изобразительного канона буддизма. Рассматриваемое в этом источниковедческом плане сочинение «Жизнеописание Цзонхавы», относящееся к жанру «намтар» агиографической литературы, представляет несомненный интерес для тибетологов и монголоведов, историков культуры северного буддизма и искусствоведов.

Монголчуудын бурханы шашин

БАЯНСАН ЛАМ

Өвөр Монголын Буян дэлгэрүүлэх хийд, БНХАУ

Монгол үндэстэн бол өөрийн уг хэл, үсэг бичиг, соёл, ёс заншилтай ба шашин суртахуунтай. Баатарлиг нүүдэлчин үндэстэн юм. Монгол нутагт аль эрт хоёр мянган жилийн тэртээ бурханы шашин дэлгэрсэн түүхтэй. Үүнэй сүүлээр Уйгараар дамжин бурхан шашин Монгол оронд дэлгэрсэн түүхтэй байдаг. Дараа нь Чингис хааны үед Сачаагын Гунга Нямбу ламтай харилцсан харьцаа холбоо байдаг. 1247 онд Гуюг хаан төвдийн Сача бандида Гунга Жалцан ламыг залж Монгол оронд бурхны шашин дэлгэрүүлэв. 1256 онд Монголын Мүнх хаан Төвдийн Гарма багшыг урьж Монголын нийслэл Хара Хоринд хүлээн авч уулзаад улсын багша үргэмжилж алтан эмжээртэй хар малгай, алтан тамгаар шагнав. Одоо нийгэмд алтан эмжээртэй хар малгай уламжлаад 17 дүр болж байна. 1253 онд Юань улсын Хубилай хаан Төвдөд элчин томилж, Сача бандида Гунга Жалцныг залсан боловч таалал болсон болхоор Пагба лам абага Гунга Жалцныг төлөөлж ирсэн юм. Хубилай хаан Пагба ламыг Бээжинд хүлээн авч уулзаад, хожмоо улсын багша, хааны багша үргэмжлээд Монголд дөрвөлжин үсэг зохиогоо. 1318 онд Монголын Буянт хаан Төвдийн Алтан Ганжуурыг бичүүлхээр, алт 900 лан, мөнгө 150 лан ба Хитадын бүх цаас үлэмж арвин үргэв. Үүнээр Төвдийн хамгийн анхны зарлиг шастирын эмхэтгэл болох Нартан хийдийн Ганжуур Данжуурыг бичиж бүтээв. Хожмонь төвдийн эрдэмтэн Будон Ринчендуб Нартан хийдийн “Ганжуур Данжуураар” эх болгож дээр нь эдүй тэдүй зарлигын зохиол ба мянга илүү шастирын зохиолыг нэмээд Шалуу хийдийн Ганжуур Данжуурыг бичиж бүтээж ээ. 1578 онд Монголын Алтан хаан Төвдийн Содном Жамса ламыг “Далай лам” хэмээх цол үргэмжилсэн байна. 1587 онд Харчинай Аюша Гуш Монгол галиг үсгийг зохиосон байна. 1645 онд Монголын Гэгээн гуш хаан Төвдийн Лубсан Чойджи Жалсан ламыг “Банчен богд” гэж үргэмжилэв. 1629 онд Монголын Лигдэн хутагтын хааны зарлигаар Гунга Одсер Бандида тэргүүнтэй олон эрдэмтэн ламнар монгол үсгийн “Алтан Ганжуур” орчуулан бүтээв. Нийт 113 боть гар бичмэлийн судар болно. 1648 онд Ойрат Монголын Заяа Бандида Намхай Жамсо ойрат монголын аялгууд зохицуулж тод үсгийг зохиосон байна. 1686 онд Халхын Ундэр Гэгээн Занабазар Соеомбо үсгийг зохиосон байна. 1905 онд Оросын холбооны буриадын лам Агван Доржиев вагиндра үсгийг зохиосон байна. Агван гэдэг төвд нэр бөгөөд санскрит хэлээр вагиндра гэдэг болхоор, бас вагиндра үсэг гэдэг ээ. 1720 онд Энх Амгалан хааны үед Ганжуурыг дахин бүридхэн орчуулж хянаж барлан бүтээв. Үүнийг Лигдэн хааны Алтан Ганжуураас эх авсан. Нийт 200 гаруй эрдэмтэд оролцсон байгаа. 1741 оноос 1742 он хүртэл “Мэргэд гарахын орон” хэмээх таван ухааны толь бичиг улсын багша Жанж Хутагт тэргүүнтэй эрдэмтэн мэргэд найруулж зохиов. 1742 онд Данжуурыг монгол хэлээр орчуулах ажил хийж эхэлж. 1749 онд бүх ажлыг долоохон жилийн дотор амжилттай төгсөв. Тус удаа Жанжа хутагтаар толгойлуулсан 200 илуу лам эрдэмтэд оролцсон байна. 1828 онд Монголын их эрдэмтэн Агван Дандар Лхарамба “Монгол үсгийг ёсны сайтар номлосон хэлний чимэг хэмээх оршибой” хэмээх монгол хэлний зүйтэй бичэв. Энэ манай босоо монгол үсгийг зөв бичихэд маш чухал хэлэн зүй болсон байна. Бас төвд хэлэн зүй “Гучид хийгээд бэлигын оруулин утга ийг амархан ойлгохоор хуран номлосон түгэс хувьтны сэтгэлийн лянхуа нээх нар хэмээх оршибой” хэмээх хэлэн зүйл бүгд төвд үндэстний дунд одоо болтол чухал хэрэглэж байгаа төвд хэлзүй болно.

Бурханы шашин олон зууны тэртээгээс монгол үндэстний дунд дэлгэрч, монгол үндэстний соёлыг их баялагжуулсан олон үеийн лам багшанарын хичээл зүтгэл болно.

Алтайн тувачуудад шарын шашны нөлөө ба өнөөгийн тулгамдсан асуудлууд

Бадарч БАЯРСАЙХАН

Монгол улс

Монгол улсын угсаатныг бүрдүүлж буй олон угсаатны бүлгүүдийн нэг нь Алтайн тувачууд юм. Алтайн тувачууд хэмээн нэрлэгдэж буй ард түмэн өнөө цагт Монгол улсын Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Ховд аймгийн Буянт сумм, Төв аймгийн Заамар, Дарханы Орхон зэрэг сум, орон нутагт бөөнөөрөө болон тархан, мөн түүнчлэн БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт аж төрж байна [1].

Алтайн тувачууд буюу Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд амьдардаг тувачууд нь монголчуудын нэгэн адил түүхийн нэн эртний үе болох овгийн байгууллын үед үүссэн тэнгэр шүтлэг, бөө мөргөл дагнан олон мянган жилийн хөгжлийг

туулсаар, мөн түүнчлэн XVII-XVIII зууны үеэс шарын шашны нөлөөнд автан өнөө үед зохих ул мөрөө үлдээсэн ба зарим талаар мартагдан гээгдэх шатанд тулаад буй билээ. Энэ удаа бид Алтайн тувачуудын дунд шарын шашны үүсэн хөгжсөн тухай болон өнөөгийн тулгамдсан асуудлыг чухалчлан тодруулахыг зорив.

Манжийн дарлалын үед Ховдын хязгаарын Алтайн урианхайн долоон хошууны 3 хошууг (хөх мончоог, цагаан соён, хар соён) Алтайн тувачууд бүрдүүлж байжээ. Дээр дурдсан гурван тува хошуу тус бүр нь өөрийн хийдтэй байсан байна. Шарын шашин XIII зууны үеэс эхлэн Монгол улсад, аажмаар тус улсын баруун зах хязгаарт Алтайн тувачуудын дунд тархан анхны хийдийн шавыг байгуулсан түүхтэй ажээ.

Ёст гүний хошууны мончоогийн хийд нь Рашдэчэнлин (төвд. *bkra shis bde chen gling*) нэртэй 1864 онд өнөөгийн Цэнгэл сумын төвд, Эетэй гүний хошууны цагаан соёны хийд нь Дамбадаржаа (төвд. *bstan pa dar rgyas*) нэртэй 1920 онд Загаст нуур хэмээх газарт, Зоригт гүний хошууны хар соёны хийд нь Рашчойлин (төвд. *bkra shis chos gling*) нэртэй 1928 онд Харганатын голд тус тус байгуулагджээ [2]. Энэ мөчөөс эхлэн 1936–37 он хүртэл дээрхи гурван хийд нь шашны үйл ажиллагаагаа явуулан, байгаль дэлхий, нутаг орноо баясган, сүсэгтэн тува олондоо буян хишиг, ариун номлолоо хүртээл болгож байгаад нийт Монгол даяар эхэлсэн хэлмэгдэлийн жилүүдэд лам хуврагуудыг баривчлан, хийдийн бүх бурхан шүтээн, ном судар, эд хөрөнгийг хураан устгасны улмаар хийдийн үйл ажиллагаа өнөөг хүртэл бүрэн зогссон байна [3].

1990 оны Монгол даяар эхэлсэн ардчилалын улмаар үндэсний уламжлал, шашин шүтлэгээ сэргээх, хойч үедээ уламжлуулах ухамсар, үндэсний үүрэг, оролцоо, идэвхи санаачлага шаардагдаж, 2006 оноос эхлэн Цэнгэл сумын тувачуудын эрт дээр үед байсан бурхан шашны хийдүүдийг сэргээн босгох, сүсэгтэн олны сүсэг бишрэлийг хамгаалах тулгамдсан нэн тэргүүний асуудал болсон байна. Энэ асуудлаар тус нутгийн уугуул иргэд хэд хэдэн төсөл боловсруулан, аймаг, сумын удирдлагуудад мөн шашны байгууллагуудад удаа дараа хандсан боловч [4] эдүгээ 10 гаруй жилийн хугацаанд ямар нэгэн бодит биелэлээ үл олсон нь зүй ёсны харамсалтай бөгөөд өнөөгийн тулгамдсан асуудлуудын нэгэн болсоор байна.

Ишлэл татсан ном зүй:

1. Баярсайхан, Б. – Баатархүү, Б.: Алтайн Тувачуудын дунд ажилласан хээрийн шинжилгээний экспедицүүд // *Монголын соёл, урлаг судлал*. Боть XIX. Улаанбаатар 2016, т. 7–15.
2. Бямбажав, Х.: Буддийские монастыри трех тувинских хошунов алтайских урянхайцев // *Ученые записки* Вып. XXIII. Кызыл, с. 110–115.
3. *Монголын сүм хийдийн түүх*. Тагнуулын төв архив. Эрхлэн хэвлүүлсэн Б. Эрдэнэбилэг. Улаанбаатар 2012, 257 х.
4. Амархүү, Ө.– Одхүү, Э.: «Рашдэчинлэн» хийдийг бүрэн засварлан сэргээх төсөл. Цэнгэл сум 2007

Халхын II Богд Жавзандамба ба манжийн хааны харилцаа: III Богдыг Төвдөөс тодруулах болсон шалтгаан (XVIII зууны сүүл хагас)

П. Баярцэцэг

Монгол Улсын Их Сургууль, Монгол улс

Монгол улсын гадаад харилцааны түүх, Монгол дахь буддын шашны түүх, нэн ялангуяа XVIII зууны эхэн үеийн Төв болон Дундад Азийн олон улсын харилцааны түүх хийгээд зарим түүхэн бие хүмүүс, хутагт, хувилгаадын намтар, үйл ажиллагааг судалсан нэгэн сэдэвт зохиолуудад Монгол, Төвдийн харилцааны аль нэг асуудлыг чухалчлан хөндөн авч үзсэн байдаг. XVII–XVIII зууны эхэн үеийн Монгол-Төвдийн харилцааны ба Төв Азийн олон улсын харилцааны түүхийг судлахад түүхэн үйл явдлыг нүдээр үзэж, чихээр сонсож дуулсан элчин, жуулчдын бүтээл, тэмдэглэл, эрх баригчдын харилцан бичилцэж үлдээсэн албан бичиг, албан захидлууд судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж байна. Тухайлбал: Эл үеийн Халх монголын нөлөө бүхий хутагт, хувилгаад, Богдтой төвдийн хутагт хувилгаадүүд харилцаж байсан захидал, айлтгал, албан бичгүүдэд хоёр улсын харилцааны чухал баримт хэрэглэгдэхүүнүүд олон байна.

XVIII зууны Монгол-Төвдийн харилцааны түүхэнд холбогдох монгол, төвд хэлээр буй сурвалж, хэрэглэгдэхүүний мэдээ баримтыг бололцооныхоо хэрээр илрүүлэн олж, шинжилгээний эргэлтэд шинээр оруулах, тухайн үеийн монголын нөлөө бүхий тэргүүн хутагттай Төвдүүд харилцаж байсныг нэхэн тодруулах, түүндээ тулгуурлан хоёр орны хооронд болж байсан түүхэн үйл явдлаар дамжуулан уг асуудлыг нэгтгэн шинжилж, зохих үнэлэлт дүгнэлт хийх нь эрдэм судлалын хувьд их ач холбогдолтой юм.

Хоёрдугаар Богд Лувсамдамбийдонмэ монголын шашны тэргүүн, монголчуудын оюун санааны тусгаар тогтнолыг илэрхийлэгч байсан юм. Тиймээс Халхуудыг алдахгүй байя гэвэл Богд Жавзандамба хутагтыг алдахгүй байх хэрэгтэй гэсэн Манжийн бодлого маш хүчтэй хууль мэт үйлчилж байсан нь түүхэн сурвалж мэдээнээс тодорхой харагдана. Өвөрмонголын судлаач Чэнь Го Гань хятад сурвалжид буй Хоёрдугаар Богд, Манжийн хааны харилцааны талаар чухал мэдээ сэлтийг дэвшүүлсэн байна. Хоёрдугаар Богдын бага нас Манжийн хааны чанга хараа хяналт дор өнгөрч байсан тухай туршлагатай түүхчдийн нэлээдгүй судалгаа бий.

XVIII зууны тэргүүн хагаст Манж Чингийн цэрэг улс төрийн бодлогын гол зорилго нь Зүүнгарын хант улсыг эзлэн авахад чиглэгдэж, үүний тулд Халхыг Зүүнгартай хийх дайны түшиц газар болгон ашиглаж байсан явдал юм.

1755–1758 онд Монгол оронд Манжийн дарангуйллыг эсэргүүцсэн ард түмний зэвсэгт хөдөлгөөн хүчтэй өрнөсөн явдал нь Монголд, монголын дотроос гарсан бөгөөд бусдыг толгойлох нөлөө бүхий нэг этгээдийг урьдын адил байлгаад байвал, тэр нь нэг мэдэхэд монголчуудын санал хүчийг хуралдуулж, Манжийг эсэргүүцсэн үйл ажилд бусдыг зохион байгуулж болзошгүй гэж манж нарыг болгоомжлоход хүргэж Хоёрдугаар Богдыг 1757 онд нас нөгчсөнөөс хойш Богдын хойт дүрийг Монголоос тодруулахыг эцэс болгосон байна.

Богдын хойт дүрийг тодруулах талаар монголын хаад ноёд ба Манжийн эрх баригчид хоёрын хооронд зөрөлдөөн гарч байсан бөгөөд тэр тухай манай улсын архивт монгол, манж хэл дээр олон тооны баримт бичгүүд хадгалагдаж байна. Нэн ялангуяа гуравдугаар Богдыг тодруулах асуудлын талаар илэрхий хурц зөрөлдөөн гарсан байна. Энэ тухай зарим баримт бичгийг дурдаж болох юм.

Mongolian Buddhism through Historical Photography: Czechoslovak Perspective

Luboš BĚLKA

Department for the Study of Religions,
Faculty of Arts, Masaryk University, Czech Republic

The contribution deals with the history of photographic portrayal of Outer Mongolia since the first visit of an American Anthropologist and (later) Czechoslovak patriot Ales Hrdlicka in the year 1912 up to the present. Although the Czechoslovak historical photography documenting the Mongolian Buddhism is not a significant asset to the pictorial treasury in comparison with the Russian and Soviet historical photography, its contribution is not negligible. This is because in particular after World War II, when the number of visitors from the West was limited due to political reasons, Czechoslovak citizens were able to take exceptional photos of Mongolian life, including Mongolian Buddhism.

On the Issue of Penetration of Buddhism to Tuva through Mongolia

Ulyana BICHELDEY – Victor SANDAKPAN Tuvan Institute of Humanities, Applied Social and Economic Researches, Russia

Buddhism finally entrenched in the territory of Tuva in the first half of the XVIII century. Considering the penetration of Buddhism to Tuva, it is important to study it in relation to the history of the Mongol empire, as Tannu Tuva Urynkhai coexisted in cooperation with the Mongolian tribes, and later all of them became parts of the same public entities.

In our view, the history of the Tuvan people and Tuvan history can not be studied separately from the history of the Mongolian people. Since the Hun period, long before the adoption of Buddhism the ancient ancestors of these two peoples roamed in the same areas, honored the same laws and the Code, worshiped the same spirits and Tengri.

Due to the fact that Buddhism in Central Asia particularly in Mongolia had the greatest development during the XVI–XVII centuries, the issue of penetration of Buddhism to Tuva started also at this time. And just from that time tengrism cults interact with Mahayana Buddhism.

From Altan Ovoo of Dariganga to a Sacred Mountain of Mongolia

T. BILEGSAIKHAN

Institute of Ethnology and Cultural Anthropology, University of Warsaw, Poland

In this paper, I demonstrate the cult of Mount Dari based on historical sources from the National Archive of Mongolia and data from my anthropological fieldwork among the Darigangas. Apart from its official name, believers often call this mountain Altan ovoo, which is an honorific title. Altan ovoo 1,354 meters, an extent volcano, is situated in Dariganga sum-district of Sukhbaatar province. In fact, Altan ovoo is the main sacred mountain of Dariganga, that is one of the Mongolian ethnic groups. Nowadays, Dariganga Mongols mainly inhabit Sukhbaatar province in southeastern Mongolia. According to historical sources, local dwellers started to worship that mountain in the XVIII century. Since that time Darigangas have been worshipping Altan ovoo except for the temporary prohibition of the ritual during the socialism.

Not only have local dwellers worshipped Altan ovoo, but other Mongolians also have venerated it. In 1913 Bogd Khaan decreed Altan ovoo to be a state sacred mountain akin to Mount Bogd khaan, Mount Otgon tenger, and Mount Khan Khentii, which were holy mountains of Khalkha Mongols. After collapsing socialism, Mongolians restored the cult of ovoo worship across the country. The president P. Ochirbat restored the state worship of Mount Bogd khaan, Mount Otgon tenger, and Mount Khan Khentii in 1995. After that Darigangas wanted to restore the state veneration of Altan ovoo and requested permission from the

president of Mongolia. As a result the president N.Bagabandi restored the veneration of Altan ovoо in 2004. Many pilgrims started to pray Altan ovoо.

Consequently, many provinces wanted to increase their sacred mountains to a state sacred mountain. This is one of the popular ongoing processes of the contemporary Mongolia For example, the president N. Enkhbayar decreed Mount Suvraga khaishan, Mount Khan-khuhii, Mount Sutaishan khaishan as state sacred mountains in 2007. The current president Elbegdorj decreed Mount Altai tavan bogd, Mount Gobi Gurvan saikhan as state sacred mountains in 2012. Nowadays, those state sacred mountains are worshiped by the head of state once in every four years.

I will discuss vividly the above issues in my work, in particularly the reverence of Altan ovoо, from history to present and from local worship to state worship.

Mongolian (Buddhicised) folk religion – a survivor throughout the centuries

BIRTALAN Ágnes

Eötvös Loránd University Department of Mongolian and Inner Asian Studies, Hungary

Being a Mongolist and first of all a philologist, I have dealt with numerous texts of various genres from written and oral traditions of many Mongolian ethnic groups. A specific and large group of texts involve the so-called folk religious text corpora (both written and oral corpora) which is one of the main target of my studies. The term “folk religion” has been used in the Mongolian academic studies, I would suggest introducing the term “vernacular religion” for the phenomenon too. In the present paper the following aspects Mongolian folk / vernacular religion will be discussed:

1. I give a definition of folk / vernacular religion among the Mongols in the historical context and in the context of the contemporary practice, referring also to the difference and similarity between “religion” and “belief”.
2. On the basis of the available sources (textual and objectual) I try to establish a paradigm for the research fields of folk / vernacular religion.
3. The folk / vernacular religion includes many aspects of practice: i) cults, ii) pantheon, iii) textual tradition, iv) presence and absence of the religious specialists, v) world of objects (paraphernalia), vi) restrictions, prohibitions, taboos vs. endurance, tolerance (including the behaviour and language usage), etc.

Due to the lack of time only a few examples with its religio-cultural context will be briefly presented in the paper: one aspect of constructing an important place of religious veneration, the home altar, one habitual action during eating (consuming every day and festive food) and a case of everyday routine of veneration of transcendental beings.

Бурханы шашны Монголын эзэнт гүрэнд үзүүлсэн нөлөө

У. Болор-Эрдэнэ

Монгол улс

Энэхүү илтгэл нь XIII–XIV зууны Монголчуудад бурхны шашны үзүүлсэн нөлөөний асуудлыг тодруулахын тулд бурхны шашин Монголд анх нэвтэрсэн үеийн түүх, Монголын эзэнт гүрний хөгжилд оруулсан хувь нэмрийг түүхэн сурвалжийн мэдээ, судалгааны бүтээлүүдэд тулгуурлан бичсэн болно.

Чингис хаан дэлхийн эзэнт гүрэн байгуулахад шашны хүчин зүйлийг төрөл бүрийн аргаар өөртөө ашигтайгаар авч хэрэглэсэн бөгөөд энэ тухай судлаач А. М. Хазанов бичихдээ “Төв Азийн түүхэнд анх удаа Чингис хаан ноёрхлоо тогтоохын тулд үзэл сурталыг чадамгай ашигласан” гэжээ (Хазанов 2004:324). XIII–XIV зууны үеийн үзэл суртал хэмээх ойлголтонд шашин багтаж байсан нь эдүгээ судлаачдын сонирхлыг ихээхэн татаж байна.

Чингис хаантай дэлхийн шашны төлөөлөгчдөөс хамгийн түрүүнд дундад улсын гүн ухаантан Даосын шашны бумба Чань Чунь уулзаж байжээ. Чингис хааны есөн өрлөгийн нэг Зэв жанжин шашны үзэл суртлын ашиглан Хар Хятаны улсыг ямар ч байлдаангүйгээр эзлэн авч тухайн нутагт бурханы шашныг дэлгэрүүрэх нөхцөл боломжоор хангаж өгөв.

Их Монгол улсын эрх баригчдаас бурханы шашиныг дэмжин анх нүүр тулан уулзаж, Төвдтэй анхлан харилцах болсон нь Өгөдэй хааны гуравдугаар хүү Годан (1206–1251) юм. Чингис хааны баримталж байсан шашны бодлогыг Өгөдэй, Мөнх, Хубилай хаан нар амжилттай үргэлжүүлсэн юм. Монголын Их хаадын дэргэд бүх шашны төлөөлөгчид зэрэгцэн оршиж өөр өөрийн шашныхаа давуу талыг ятган ухуулж, тэд Алтан урагийн ноёдууд тэр байтугай зарим их хаадуудыг хүртэл аль нэг шашинд нууцаар орсон гэх мэтээр цуурч байсан ч Их Монгол улсын хаадууд бүх шашинд адил тэгш хандаж, аль нэг шашинд өөрсдөө орохоос зайлсхийдэг байв.

Монголчуудын тухайн үеийн нийгмийн цоо шинэ үзэгдэл болох бүх шашинд адил тэгш хандах бодлого нь сэтгэлгээний жинхэнэ эрх чөлөө ноёрхсон, ёс суртахуун болон сэтгэл зүйн алив дарангуйллаас ангид байсан учир Эзэнт гүрний үеийн Монгол төрийн бодлого хүчтэй бөгөөд урт удаан үргэлжилж чадсан юм.

Сан тахилгын зан үйлд хийсэн зарим шинжлэл

Т. Булган

Монгол Улсын Их Сургууль, Философи, Шашин судлалын тэнхим, Монгол улс

Буддын шашны зан үйлийн дотор түгээмэл хэрэглэж ирсэн нэгэн зан үйлийн нэгэн бол **“Сан тахилга” (Mongolian Buddhist Incense Offerings)** хэмээх зан үйл билээ. Сан тавих нь эртний уламжлалтай бөгөөд бусад шашны зан үйлд ч бас бий. Сан тавих зан үйл нь дотроо зорилго агуулга зэргээсээ хамаараад олон төрөл зүйлд ангилагдаж болохоор харагдана. Хүний амьдралын янз бүрийн хэрэгцээ шаардлагатай уялдаж тийм агууламжтай болсон байна. Хувь хүний амьдрал ахуй, Ёс заншил, хүндэтгэл бишрэл, оршихуй байгаль дэлхий шүтэлцээ, төр шашны гээд амьдралын элдэв хэв маягийн хэрэгцээнээс үүлдэлтэй Энэ удаагийн илтгэлээр Монголчуудын дунд өргөн хэрэглэгдэж ирсэн 19-р зууны Монголын эрдэмтэн **Цорж Агваандоржийн зохиосон “Тэнгэр, дэлхий, газар орны сан тахилга оршвой” хэмээх бүтээл дэх сангийнтахилгын талаарх зарим нэгэн мэдээг та бүхэнтэй хуваалцах зорилго тавьсан юм.**

Үүнийг дараа хэдэн зүйлд багтаав. 1. Уг сан тахилгын ерөнхий зураглал (**General view on the Text**) 2. Заллага, 3.Тахил өргөх 4. Наминчлал гэмшихүй ёс 5. Соёрхол талбих 6. Хишиг даллах 7. Өлзий өршөөх гэсэн хэсгүүдээ томъёолж гаргахыг хичээв. **Тахил (The genre of Incense offerings):** “... Сүү, цай, архи, айраг, тараг, хоормог, аарц, өрөм, амтат жимс, мах таташ, гурил, тос тэргүүтэн элдэв идээний дээж, зоог хуримыг өргөмү.” **Ариусал (Purification by Offerings Incense):** “... Агар, зандан, агь, ганга, арц тэргүүтэн элдэв үнэртэнийг багсаруулан шатаасан утаа бээр дэлхийн эзэд юугаа ариусгамой. Хамаг бузар түйтгэр аригуутах болтугай.”

Эдгээрийн дотроос Наминчлах ёсыг тусгайлан авч үзсэн. Энэ нь шашны зан үйлийн нэг чухал суурь ойлголт байдагтай холбоотой гэж үзэж байна, Зарим тохиолдолд үүнийг хорио цээр буюу цээрлэх ёстой холбож үздэг. (Жишээ нь: шашин судлалын ухаанд тал ажиглагдсан.)

Наминчлал (Confession of all faults):

- Цөвийн цагийн бид мунхаг балмадын эрх бээр хишүү хярвас шатаасны бузар буртаг талбигсан
- Хорхой араатан гөрөөсийг хорлосон
- Газар усыг хөндсөн
- Мод огтолсон
- Чулуу ховхолсон
- Улай гаргасан
- Хэрэлдэн шуугилдсан
- Онгон газар буудал зассан
- Орны тэнгэр, дэлхийн эзлийг эс хайхарсан
- Ач тусыг мэдэж цаг цагт эс тахисан
- Цог жавхланг бадруулах ба газрын шим арвидахын арга дээр эс хичээнэ
- Дэлхийн эздийн таалал дор харшилсан бүхнээ ... дуудан наминчилмой.

... Товчилвоос:

- Орон дэлхийн эздийн таалал дор харшилсан
- Сүр буяныг гутаасан
- Мөн өөрийн заяа буяныг булаалдсан
- Орон дахины сайнбг хомсодгосог
- Мууг элбэгшүүлэх, муу явдлаар явсан хамаг бүхнээ дуудан наминчлму. Өршөөж хүлцмү. Ивээгчид минь ээ.

Хишиг даллах(recalling all the best wishes):

... Он цаг тагш, гэм үгүй
Олз ашиг усрах
Тариа өвс бөрөг шимтэй
Эсэн эх бээр жаргуулмой

Дүгнэлт (Conclusion):

1. Буддын шашны Сан тахилгын зан үйл бол хүний амьдралын шаардлагаас нөхцөлдөж буй болсон түүнтэй хамт хөгжиж ирсэн амьд бодит зан үйлийн нэгэн

2. Энэ зан үйл нь зөвхөн ахуйн хэрэгцээг хангаад зогсохгүй хүний дотоод сэтгэл санааны хөгжилд зөв чадварыг авчрахад туслагч зан үйлийн эерэг хэлбэр
3. Энэхүү зан үйл Хүн байгалийн шүтэлцээт оршихуйн учир утгыг зөв сэхээрсэн, амьдралын зөв хандлагыг шингээсэн, ахуйг зөв оносон онол сэтгэлгээнд суурилсан сэтгэлгээний зан үйл гэж үзэж байна.

Уран Я. Гимбэл ламын сийлбэрлэсэн модон бар, барласан номуудын тухай

Р. Бямбаа

Варшавын Их Сургууль, Польш улс, Монгол улс

Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн цагаас эхлэн монголын ихэнх сүм хийдүүд дэргэдээ барханы газрууд байгуулан, дийлэнхдээ төвд номын бар сийлбэрлэж, төвд ном судрыг хэдэн зуун төрлөөр нь барладаг байжээ. Бас цөөхөн сүм хийдэд ч монгол номын бар сийлбэрлэж, монгол ном судрыг ч хэвлэдэг байсан байна. Монголчуудын тэрхүү монгол, төвд номын бар сийлбэрлэх, барлах уламжлал бол үндсэндээ 1930–1938 оны төрөөс шашин сүм хийдийн эсрэг явуулсан хатуу бодлого, улс төрийн хэлмэгдүүлэлтээс болж тасарсан гэж хэлж болно. Тэрхүү тасрах шахсан номын бар сийлж, барлах уламжлалыг авч үлдэн, үндсэндээ өнөөдрийг хүртэл үргэлжүүлсэн гавьяатай хүний нэг бол уран Я.Гимбэл лам юм.

Уран Я.Гимбэл лам нь одоогийн Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт Зоогийн энгэр гэдэг газар 1907 онд мэндэлсэн. 2000 онд бурханы орон заларсан. Гимбэл гуай бага наснаасаа Дэлгэрийн Чойрын хийдэд сууж эрдэм боловсрол олсон төдийгүй монголын алдартай эрдэмтэн түүхч Зава Дамдин буюу Лувсандаян(1867–1937)-гийн ойрын шавь нарын нэг нь байсан.

Уран Гимбэл гуай Дэлгэрийн Чойрын хийдэд шавилан сууж байх цагаасаа мод, чулуу, төмрөөр элдэв зүйл хийж оролдож байсан бөгөөд түүгээр ч барахгүй номын бар сийлэхийг ч мөн сурсан байна. Тэрээр энэ сурсан эрдэмээ, сүм хийд хаагдсанаас хойш орчлонгийн мөнх бусыг үзүүлэх хүртлээ орхилгүй номын бар сийлэх ажлаа нууцгайгаар хийж байжээ.

Гимбэл гуай өөрөө амьд сэрүүн тунгалаг байхдаа надад өгч байсан, бидний олж үзсэн болон цуглуулсан номуудаас барагцаалж үзвэл одоогийн байдлаар Гимбэл гуай их, бага 100 гаруй нэр төрлийн судар номын хоёр талд нь сийлсэн, урт, богино нийлсэн 3000 гаруй модон хэв, мөн бурхад болон сахиусны барууд сийлбэрлэсэн байна. Гимбэл гуайн барын нь сийлбэрлэсэн номыг бүхэлд нь авч үзвэл: Ганжуур, Данжуурын доторх номууд, шашин зан үйлийн холбоотой номууд, залбирал, магтаал, ерөөлүүд, бичиг үсгийн номууд гэх мэт байна.

Энэ бүх номуудын барыг сийлбэрлэх ажлыг өөрөө дангаараа хийсэн бөгөөд харин бар сийлбэрлэх хус модыг олох, бэлдэх ажлын ихэнхийг бол Гандантэгчинлин хийдийн лам, Дэлгэрийн Чойрын унаган шавь, Зава Дамдин буюу Лувсандаянгийн ойрын шавь нарын нэг Н.Гончигдорж (1907–1997) гуай хийж байсныг би мэдэх билээ. Харин Гимбэл гуай сийлбэрлэсэн бараараа ном барлах ажлыг өөрөө хийхээс гадна өөрийнх нь шавь А.Лаган (1913–1992), түүний эхнэр Б.Цэвэл(1921- одоо амьд сэрүүн байгаа), охин Отгонтуяа, Соёлмаа, Энхжаргал, Үржинцэцэг нар голлон барлаж байсан бөгөөд одоо хүртэл энэ гэр бүлийнхний үр хүүхдүүд, өндөр настай Цэвэл гуай нар багшийнхаа бүтээсэн номын бараас “Доржжодва”, “Сүнчэн дэн-а”, “Бардо солдэв”, “Ганжуурын хураангуй” тэргүүтэн судрыг нь барлаж бүтээсээр байна.

Мөн Гимбэл гуайн өргөмөл хүү Гармаадорж, охин Цэндмаа нар болон лам шавь Ганбаатар тэргүүтэн олон лам шавь нар нь ч гэсэн 1990 оноос хойш олон нэр төрлийн судар номыг нь хэдэн зуугаар нь барлаж тарааж байсан билээ.

Гимбэл гуай номын бар сийлэх ажлыг өөрөө хийгээд зогссонгүй хойч үедээ уламжлуулах үүднээс нилээн хэдэн залуучуудад сургаж байсны зарим нэг нь бол Гандантэгчинлин хийдийн лам Алтан-Очир, Да лам Бямбажав, бурхан ч лам Пүрэвбат нар юм.

Тиймээс Гимбэл гуайн модон бар сийлбэрлэж бүтээх, ном барлах уламжлалыг таслалгүй авчирсан энэ сайхан уламжлалыг бас их бага хэмжээгээр хойч үедээ бас дахин уламжлуулах ажлыг сүм хийдүүд дахин сэргээх, судлаачид судлах нь зүйтэй бол уу?

A Tibeto-Mongol Buddhist monastery and a Chinese Buddhist monastery in present-day Hohhot, Inner Mongolia: competition and interactions

Isabelle CHARLEUX

Group Societies, Religions, Secularizations (GSRL-CNRS), France

This paper investigates the architecture, icons and activities of two Buddhist monasteries—the (Tibeto-)Mongol Yeke Juu (Ch. Dazhao[sī]) and the Chinese Buddhist Guanyinsi—of Hohhot’s Old City (Inner Mongolia). Both monasteries were enlarged in 2005–2006 in the context of the economic boom, the rise of ancient and new forms of religiosities, and the rapid development of tourism. If the monk communities are still ethnically divided, it is not the case of the lay devotees anymore.

My aim is to analyse the competition between the two monasteries, the religious interactions, influences and exchanges (including syncretic tendencies inside the monasteries), and the impact that they have had on the city: how does the city change religion(s), and how religion(s) in turn change the city?

Research on the Buddhist Philosophy in Mongolia and it's Persuasive Issue

CHULUUNBAATAR Gelegpil
BADAMKHAND Shagdar
ARIUNZIL Baasanjav

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences, Mongolia
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences, Mongolia
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences, Mongolia

In the association with major role in the development of philosophy and thinking alignment of the humankind that research on the concepts, theory, consolidative trends and origination of the Buddhist philosophy such regards with ancient traditions in reflection with present and time of harmony. We attempts to consider the following aspects of this paper:

- Within the framework of the causes and categories of Buddhist philosophy in considering with the same level of non-used concept of discrepancies such attentions to basis on the affecting and classifications of philosophy,
- In the framework of the rational philosophical concepts in the reciprocal use of Western philosophy such developed issues on the thinking concepts,
- A detailed studies on that methods of thinking such is developed by Mongolian thinkers, in order to make real contributions to the development and affirmative consolidation of Buddhism and Mongolian scholars' contributions in order to organize dispute about the appropriate formulation emphasizes that the Mongolian Buddhist philosophy,
- Adaption to that designed vocabulary of Buddhist knowledge productiveness such covered by effective as straightness and modern needs of each philosophical terms and mapped requirements, as well as proposed activities of study of Buddhist philosophy and its non-stop process with an overview of some of the problems facing in-depth development and improving with a good quality of performance in the further.

Mongyol orun-du delgeregsen «Rasiyan-u dusul»-un töbed eke kiged tegün-ü mongyoljiysan jīm-a

Borjogin ČILAFU

Töb-ün ündüsüten-ü yeke suryayuli, Minzu University of China, China

Боржогин Чилафу
«Расийн-у дусул»-ын төбөд еке кигед тегүн-ү монголжигсан жим-а
Төб-үн үндүсүтөн-ү yeke suryayuli, Minzu University of China, China

Qalimay-tu barlaydayсан todu üsüg-ün qoyar «Altangerel»-ün qaričay-a

ČOLMONGEREL

Töb-ün ündüsüten-ü yeke suryayuli, Minzu University of China, China

«Алтангэрэл»-үн қаричай-а
Төб-үн үндүсүтөн-ү yeke suryayuli, Minzu University of China, China

«Алтангэрэл»-үн қаричай-а
Төб-үн үндүсүтөн-ү yeke suryayuli, Minzu University of China, China

Significance of the Four Demons in Sutra tradition, in meditation practice and according to Machik Labdron in the Chod tradition

Zoltán CSER

Dharma Gate Buddhist College
Department of Mongolian and Inner Asian Studies, Eötvös Loránd University, Hungary

When we talk about the enlightenment of the Buddha we can encounter the phenomena of the Four Mara, or Four Demons that are the obstacles in the process of realization. There are different renderings how the Four Maras are connected to the so called Four Veils that covers the enlightened mind. To understand this is the key to comprehend how the stages of meditation are connected with the obstacles. In one meditation, like observing the breath the practitioner meets these obstacles, challenges, this way can clearly see the levels of mind, or layers of mind and apply the antidotes to these obstacles. There are different ways how the demons or Maras are depicted in the Pali texts, or Mahayana literature, Vajrayana scriptures and in the Dzogchen teachings. As one of the main feature of Tibetan Buddhism and Mongolian Buddhism the Chod practices also involve the sutric and tantric methods. If we see the commentaries also we can find that Chod practice contains elements from Mahamudra and Dzogchen practices. In the Chod root text Machik Labdron clearly defines what the Four Demons are, hence the whole practice is based on the stages of overcoming these demons. According to Machik the Four Maras are different, we will try to answer why. The key to connect the different interpretations is understanding the stages of meditation.

Ямандага бурханы гал мандал үйлдэх зан үйл

Бэхийн ДАРАМБАЗАР

“Цогт Цагийн Хүрдэн” соёлын төв, Mongolia

Хүмүүний амьдралд тохиолдох саад тотгор, ган зуд, өвчин зовлон тэргүүтэй байгалийн сөрөг элдэв үзэгдлийг амарилуулан хүмүүн амьтныг зовлон зүдүүрээс ангижруулж амар амгалан аж төрөх, улмаар гэгээрэлд хүрэх зам мөрийг нээх арга нь нууц тарнийн дээд ёсны их хүчит Ямандага бурханы гал мандал үйлдэх зан үйл юм. Ямандага бурхан болбоос гурван орныг нэгэн агшинд эрхэндээ оруулж муу бүхнийг даран амарлиулж сайн сайхныг дэлгэрүүлэх хүч чадал бүхий ам тангарагтай дандарын ёсны дээд ёогийн бурхан болой.

Ямандага бурханы (түвдээр: жинсрэг) гал мандлыг амарлиулах, дэлгэрүүлэх, эрхэнд хураах, хатуу үйл гэсэн дөрвөн үйлийн үүднээс өргөж хамаг амьтны тусыг үйлддэг. Амарлиулах үйл нь өвчин зовлонг амарлиулж үйлдэх, дэлгэрүүлэх үйл нь ном буян сайн үйлийг дэлгэрүүлэх, эрхэнд хураах үйл нь хамаг амьтныг эрхэндээ хурааж зөв үйлд оруулах, хатуу үйл нь гай барцад, ад зэтгэр, хүмүүн хийгээд хүмүүн бусыг хорлолыг буцаах утга агуулгатай.

Бид энэхүү илтгэлдээ Ямандага бурханы жинсрэг буюу гал мандал үйлдэх зан үйлийн утга учир, хэрхэн үйлдэх ёсон, тус эрдэм зэргийг судар номд тулгуурлан өгүүлэх болно.

Монголчуудын уул, ус тахих зан үйл: уламжлал, шинэчлэл

Р. ДАРЬХҮҮ – Д. ОЮУНГЭРЭЛ

Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Хүмүүнлэгийн салбар, Философи, шашин судлалын тэнхим, Монгол улс

Энэхүү илтгэлдээ бид монголчууд эртнээс эдүгээ хүртэл байгалиа хайрлан хамгаалж ирсэн уламжлалт зан үйлийн нэг болох уул, ус тахих зан үйлийн үүсэл, уламжлал, шинэчлэлийн асуудлыг холбогдох судалгааны бүтээлүүдэд үндэслэн авч үзлээ.

Монголчуудын байгаль орчноо хайрлан хамгаалах нэг арга ухаан болох уул, ус тахих зан үйлийг нарийвчлан судалж, энэ уламжлалт зан үйлийг орчин үед хэрхэн шинэчлэх асуудал анхаарал татаж байгаа болно. Учир нь хүмүүний амьдрал байгалиас ихээхэн хамааралтай билээ. Өнөө үед байгаль орчин доройтох болсон нэг шалтгаан бол монголчуудын хувьд байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт зан үйл их алдагдсантай холбоотой.

Монголчуудын хувьд уул, усаа тахих зан үйл нь анх бөөгийн шүтлэгтэй холбоотойгоор үүсч, улмаар бурханы шашны нөлөөг авч эдүгээ хүртэл уламжлагдан шинэчлэгдэж иржээ. Уул, ус тахих зан үйл нь байгалийг хүндэтгэн дээдэлж, од, гараг эрхэсийн орчил хөдөлгөөний хамгийн сайн тохиол буюу сайн өдөр, цагийг сонгож, нутгийн ард олон тухайн нутаг орондоо хамгийн ихээр хүндэтгэн дээдэлдэг уул, усандаа идээ, ундааныхаа дээжийг өргөн хүндэтгэл үзүүлж, сүсглэн залбирч, мөргөл үйлдэх ёслол буюу нүүдэлчин монголчуудын байгалийг шүтэх шашин-соёлын чухал өв юм.

Монголчуудын уул, усаа тахих зан үйл нь хүн-байгалийн хүн холбоог эрхэмлэн дээдэлсэн монгол бурхны шашны өв бөгөөд энэ сайхан соёлоо хэрхэн өвлөн уламжлуулах, шинэчлэх талаар бид өөрсдийн саналыг илтгэлдээ дэвшүүлж байгаа болно.

Өгүүлэлд бурханы шашны сурвалж дурасгал болох “Баатаргаа явагч судар”-ыг танилцуулж, орчин үед уг судрыг хэрхэн суралцаж, судалж, бясалгаж байх талаар өгүүлнэ.

Buddhist lamas and monks: On the brink of tradition and reform (beginning of the XX century)

D. DASHDULAM

School of Arts and Sciences, National University of Mongolia, Mongolia

Mongolia's Buddhist religion has existed for many hundreds of years in inseparable relationship with the history, culture, customs, traditions and livelihood of the Mongolian people, and there was a tight connection between the state and religion based on particular delicate reasons that, in some cases, reach the level when state matters were influenced through religion.

In my report, I will touch upon the issue of how the situation related to Buddhist lamas and monks in Mongolia changed in 1920–1930-ies, causes and circumstances of such changes, and how the policy by the newly established state toward Buddhist lamas and monks changed the relationship between lamas and monks, believers and the state.

On the other hand, as the temples and monasteries had a strong and incessant influence on believers, the state implemented a consistent policy aimed at weakening, disrupting and further eliminating such influence. While implementing this policy, the state managed to target all, starting with ordinary monks to high lamas and saints.

Although the people's government declared that it brought out monks and lamas from unhuman traditions and darkness of the previous society, and changed their inactive state of settling around temples and monasteries into a more socialized and active state, but the truth was that it cut off one of the main vessels that supplied unique nourishment to Mongolians' mentality, way of thinking and national immunity. It is time to revise the policy implemented by the people's government toward temples and monasteries, and give it a careful reconsideration from a diverse new angle.

For instance, after the triumph of the revolution, Bogdo Jibzundamba VIII, who was left only with his religious rights and as the head of religion, was separated from state affairs; his influence was limited and coordinated by the Oath Agreement. In 1924, after his death, they managed to completely forbid finding new incarnations, which was the state stance aimed at not allowing searching for reincarnations of noble lamas and monks in the times to come. In addition, for the first time in Mongolia's history, they adopted the “Law on separation of state and religious affairs” (1927), thus bringing the state policy on religion onto a new level. This was a legal document that made the transition from tradition to reform legitimate.

On the edge of the XX Century, Mongolian Buddhists and believers made a huge progress in terms of social and political stance, culture and education. However, at the same time, this has set up grounds for losing their mental immunity, customs and traditions.

When Mongolians made the revolution in the first half of the XX Century, their objective was to get rid of foreign oppression and social harassment, which was more or less achieved. At the same time, changes and reforms did not bring fully positive outcomes in terms of mentality. In that sense, there is a reason to believe that consequences of the events that took place in those days may have become the basis for the numerous negative factors in the religious reforms that are taking place since 1990.

Бурханы шашны зан үйлийг тайлан тайлбарлах нь (“Шашин соёл” тайлбар толийн жишээн дээр)

Д. ДАВААСҮРЭН

Соёл Урлагийн Их Сургууль, Монгол улс

Эдүгээ нэг талаасаа нийгэмшил, хүмүүжлийн бүхий л орчин, нэн ялангуяа өнөөгийн монголын нийгэмд уламжлалт соёлын тухай төсөөлөл, мэдлэгийг бий болгоход гол үүрэгтэй Бурханы шашны зан үйлийн утгыг тайлан тайлбарлах, зарим зан үйлийг хэрхэн үйлдэх арга аргачлалыг сэргээх, шинэчлэн боловсруулах (магадгүй зарим тохиолдолд шинээр санаачлах, бий болгох) хэрэгцээ, нөгөө талаасаа XXI зуунд хүн төрөлхтөнтэй тулгарч байгаа хурц асуудлын нэг болох “хүмүүсийн хоорондох харилцааг хүнлэг энэрэнгүй болгох”¹-ын тулд ЮНЕСКО-гийн зүгээс дэвшүүлэн тавьж буй “амьдарч сурах, танин мэдэж сурах, хийж сурах, хамтран аж төрж сурах”² буюу ирээдүйн боловсролын дөрвөн үндсэн зарчмыг ханган биелүүлэх шаардлага байсаар байна.

Иймд бид энэ удаад “Шашин соёл” хэмээх “Соёл урлагийн тайлбар толь”-ийн II ботийг судлагдахуун болгож байна.

¹ Соёл судлал /Монгол Улсын шинжлэх ухаан, 25 боть/, УБ. 2009. 41 тал

² Соёл судлал /Монгол Улсын шинжлэх ухаан, 25 боть/, УБ. 2009. 41–42 тал

Энэ нь Хүмүүс; Байгууллага; Ном тогтмол хэвлэл; Эрдэм шинжилгээний хурал; Хууль тогтоомж; Зан үйл; Урсгал чиглэл; Шашны сэдэвт кино, хөгжим, бүжиг гэх 8 агуулга, 1230 толгой үг, 234 зурагтай толь болно. Үүнд Бөө мөргөл, Буддын шашин, Исламын шашин болон Христийн шашны зан үйл гэх хүрээнд “*тухайн шашны онцлогийг харуулсан, олон нийтийн оролцоотойгоор үйлддэг*”³ гэх үндсэн хоёр шалгуураар буюу хамтын үйл болох талаас нь онцлон нийт 219 зан үйл багтаажээ. Үүнээс Бурханы шашинд хамаатай нь 147 байна.

Нийгмийн бүхий л хүрээнд дахин давтагдах шинжтэй аливаа зан үйлээр дамжуулан “*хүн төрөхөөс эхлээд насан туршид ... өдөр тутмын болон сар тутам, жил тутам, тохиолдлоор, тэмдэглэлт байдлаар*”⁴ байнга суралцдаг. Хувь хүн болон хэсэг бүлгийн түвшинд “*мэдлэг, чадвар, дадал, соёлын үнэт зүйлсийг эзэмших, шинэ хандлагаар төлөвших*”-өд дан ганц зан үйл бус, зан үйлжсэн хэвشلүүд ч гэсэн чухал ач холбогдолтой юм.

Бурханы шашны зан үйлийг ард түмэн өөрсдийн санаа бодол, мэдлэгийн ихэнх хэсгийг бүрдүүлдэг, мөн хүрээлэн буй соёлын орчин нь ард түмний сэтгэлгээний хэв маяг, үйл үйлдвэрт нөлөөлдөг утгаар нь соёл судлал; Нийгмийн цогц үзэгдэл болох талаас нь олон шинжлэх ухааны уулзварт судлахдаа нийгмийн гишүүдэд мэдлэг, чадвар, дадал, соёлын үнэт зүйлсийг эзэмшүүлэх, шинэ хандлагаар төлөвшүүлэхэд зан үйлийг ашиглах өргөн боломжтой талаас нь суралцахуйн онол зэрэг бусад холбогдох онол, арга аргачлалаар гүнзгийрүүлэн судлах, тайлан тайлбарлах нь өмнө тэмдэглэсэн хэрэгцээ, шаардлагыг ханган биелүүлэхэд үр нөлөөгөө өгөх бүрэн боломжтой.

Иймд соёл урлагийн тайлбар толийн хоёрдугаар “Шашин соёл”-ын ботьд багтсан дээрх 147 зан үйлийн тайлбарыг сайжруулах замаар улам гүнзгийрүүлж, нэмэн дэлгэрүүлэх, цаашдаа үүнийг нэвтэрхий толийн түвшинд хүргэх зорилго зохион эмхэтгэгчдийн өмнө байна.

Үүний тул бид энэ удаагийн өгүүлэлдээ уламжлалт Бурханы шашны зан үйлийг олон шинжлэх ухааны уулзварт судлах, тайлан тайлбарлах хэрэгцээ шаардлага, тэдгээрийн үндэслэлийг “Шашин соёл” нэрт соёл урлагийн тайлбар тольд орсон нийт 147 зан үйлийн заримын жишээн дээр авч, холбогдох санал дүгнэлтүүдийг дэвшүүлсэн болно.

Тувачууд болон хотонгуудын буддын шашин ба уламжлалт шашин шүтлэг (Шүтлэг ба зан үйлийн бодит хэрэглээ)

Антонина Донгак

Tuvan Institute of Humanities Applied Social and Economic Researches,
Department of Mongolian Studies, Russia

Аливаа ард түмний угсаатны ухамсарын үндэс сууринд оюуны соёл, хүн төрөлхтөний уламжлалт соёлын зүг чиг, хэлний уран сайхны арга зүйн болон угсаатны аман зохиолын бүтэц систем, уламжлалт шашин шүтлэг, ахуй соёлын хэв шинж ба баяр ёслолын зан үйлийн бодит хэрэглээ оршдог болно.

Тиймээс үндэсний цөөнх болох Баруун Монголын ард түмний, тэр тусмаа түрэг гаралтай *тува* болон *хотон* үндэстэний оюуны соёлын хэв шинж, түүний онцлог өнөөг хүртэл олон арван судлаачдын сонирхолыг ихэд татсаар байна.

Монгол улсад голчлон мал аж ахуй эрхэлсэн тува угсаатан нь өнөөгийн Баян-Өлгий (Цэнгэл сум), Ховд (Буянт сум), Сэлэнгэ (Зүүнбүрэн, Шаамар сумууд), Дархан уул (Орхон сум) болон Хөвсгөл (Цагааннуур сум) аймгуудын нутаг дэвсгэрт бөөнөөрөө болон тархан амьдарч байгаа билээ. Түрэг гаралтай хотон үндэстэн нь Баруун Монголын нутаг дэвсгэрт гурван зуу гаруй жилийн туршид аж төрөн эдүгээ төрөлх хэлээ мартан, ойрад ард түмний нэгэн хэсэг болон Увс аймгийн Тариалан сумын нутаг дэвсгэрт амьдарч байна. Эдгээр угсаатны зарим хэсэг нь Сэлэнгэ аймагт, Улаангом, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудаар өөрсдийн түүхэн болон угсаатны үндэс сууриа хадгалан тархан суурьшсан байна.

Хэдий ч цөөнхийн тоо, орчин үеийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж буйг үл харгалзан Монгол дахь тувачууд өнөөг хүртэл өөрсдийн төрөлх хэлээ, оюуны өвөрмөц соёлоо хадгалан үлджээ. Ард түмний оюуны соёл нь үлгэр домгийн ухамсар болон бөө мөргөлийн шүтлэг, буддын шашны итгэл үнэмшил дээр тулгуурлан хүмүүсийн оюун санааны соёлын агуулга тэдгээрийн гарал, хэв шинж, угсаатны онцлог дээр хадгалагдан үлддэг ажээ.

Эрика Таубегийн тэмдэглэснээр Монголын тувачуудын зан үйлийн шүтлэг нь өнөөг хүртэл бөө болон буддын хоорондын ялгаа гараагүй (синкретик) үзэл ойлголт бүхий түүний дотор байнгын хатуу чанга ёс жаягийг эрхэмлэдэг байна [Таубе 1994: 12]. Өнөөг хүртэл ард түмний оюуны соёл нь эдгээр ойлголт, утга санааг илэрхийлдэг ба буддын шашин нь Монгол даяар мөн адил 1930-аад он хүртэл хүчтэй үндэс суурийг бий болгосон байна.

Цэнгэлийн тувачуудын уламжлалт зан үйлийн бас нэгэн онцлог нь зөвхөн эмэгтэй удган бөөгөөс гадна лам, эдгээгч ба өвөрмөц зөн хослол агуулсан кенгээ байдаг байна. Нутгийн ард түмэн тэднийг дахин төрсөн дээд санваартан хэмээн ихэд хүндлэн дээдэлдэг байна. Энэ нь эдгээр *кенгээ* хэмээх нэрлэгдэх эмэгтэйчүүд нь бурханы үнэнч шашны уламжлалын эсрэг байсан гэдгийг илэрхийлэх тал ажиглагддаг байна. Гэвч нутгийн ард түмний дотроос хэн ч бурхан шашны мөргөл үйлддэг хүнээр эрэгтэй хүн биш, яагаад заавал залуу эмэгтэй хүн хэмээн үл асуух мөртлөө гайхан биширдэг байна. Энэ нь мөө

³ Шашин соёл /Соёл урлагийн тайлбар толь, II боть/, УБ. 2016. XII тал

⁴ Шашин соёл /Соёл урлагийн тайлбар толь, II боть/, УБ. 2016. 113 тал

- Б. Төрөл авах зуурдын орон буюу буян, нүглийн хар, цагааны дэнсийг энд харуулна.
 В. Эх болсон зургаан зүйлийн орны ерөнхий байдлыг энэ хэсэгт харуулна.
 Г. Энэ ертөнцийн амьдралын мөн чанарыг арван хоёр шүтэн барилдлагаар харуулсан зураг энэ хэсэгт дүрсэлсэн байна.

Сансрын хүрдэнд шүтээн урлалын чөлөөт боломж илрэх нь

Шашны урлаг хэдийгээр заагдсан өнгө хэмжээтэй байх боловч бурханы ном хязгааргүй түгэх, цаглашгүй гайхамшигт чанартай учир тэрхүү чанарыг мэдэрч туурвин бүтээх юм бол хэмжээлшгүй хөгжиж болох боломжтой. Харин түүнийг нь ойлгож чадаагүйгээс юм уу хэт үзэл сурталжсан нийгмийн үзэл сурталд баригдсанаас заагдсан хязгаарт тордог байна. Харин бурханы тиг хэмжээний онолыг сайтар эзэмшин бүтээвэл түүнийг давж, авьяас чадвараа үзүүлсэн урлаачид л шинийг бүтээдэг билээ. Тэдний тоонд Өндөр гэгээн зүй ёсоор орно.

Иймээс бурхадын тиг хэмжээнд өөрчлөлт хийн дэглэхэд баримтлах хэд хэдэн зарчим байх нь гарцаагүй. Үүнээс хамгийн гол нь бурхан шүтээний хувь хэмжээнд өгөгдсөн бэлгэ чанаруудыг эрхэмлэх ба нэг бэлгэ чанарыг нөгөө сайн билгээр орлуулж өөрчилж чадах уран сэтгэлгээ, мэдрэмжтэй байх явдал юм.

Монгол зураач, урчууд бурхан дүрслэлийн тогтож заншсан онол дүрмийг ардын урлагийн ухан сэтгэмж, чөлөөт дүрслэлээр баяжуулан өөрчилж туурвисныг олон төрлийн бурхан шүтээний зураг урлал, сансрын хүрднээс харж болох юм. Жишээлбэл,

Үүнтэй нэгэн адилаар Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй Л.Дарьсүрэн гуайн 1968 онд бүтээсэн “Сансрын хүрд”-ийг чөлөөт боломж ашиглан бүтээсэн бололтой. Учир нь сансрын хүрднийг дүрслэхдээ монгол ахуйд өргөн хэрэглэдэг аж ахуйн зүйлс төдийгүй хувцас хэрэглэлийг бүтээсэн нь олонтой байна /хавсралт-зураг 10/. Тухайлбал, тамын орны хэсэгт монгол дарханы хэрэглэдэг "аварга" хөрөө, хүний орны хэсэгт монгол гэр, майхан зэргийг дүрсэлсэн төдийгүй үхэр саах, мал төхөөрөх, ус зөөх, мал хариулах зэрэг "монгол" аж байдлыг дүрсэлсэн нь аж байдлын монгол зургийг санагдуулна. Мөн энэ шүтээн зурагт дүрслэгдсэн үүл, байгаль, ан амьтад, өнгө зэрэг нь Төвд дүрслэлийн хэлбэр маягаас эрс ялгаатай, харин хожмын монгол зурагтай олон зүйлээр төстэй байна.

Buddhism and environment

ENKHTSETSEG Ayur

Business and Graduate School at School of Business and Humanities,
 Mongolian University of Science and Technology, Mongolia

In the history of Mongolia, the Buddhist lamas have manifested a harmony of live with wild nature survived in the mountain, forest and gobi desert. Tranquil life staying in the wild nature helped Buddhist practitioners to improve their inner mind and at the same time they also worked to protect the animals living in the that area. With love and tolerant heart, the Buddhists lived with the natural vegetation, wild animals in that / steppe, forest, mountain/ area for mutual survival.

Nature and conservation is one of the top issues mankind faces today. This manifest has been announced at the World Environmental Day, on 5 June 1996. World scientists, politics, and researchers through media analyzed and alarmed on the serious an impacts of toxic substances on the living environment of the humans, animals and biodiversity. Because of humans/mankind/ is the one who pollute their own health, and kill the life of all beings on the Earth. The risk threatens the ecology. Therefore, taking measures to prevent or mitigate the pollution, of world scale, including the important International Conventions to protect the environment, where Buddhists are connected learning/teaching/searching and implementing the Buddhist methods of how to protect the Environment today.

“Цагаан буяны найман чуулган” нэрт Жанрайсигийн Нүннай сахих Зан үйлийн товчлол

Ц. Эрдэнэбат

Гандантэгчэнлин хийд Монголын Бурханы Шашны төв, Монгол улс

Бидний багш дээдэс, эрдэмтэн лам нар ихээхэн бэрхшээлийг туулан өнөөдрийн бидэнд Бурханы шашин хөгжих сайн цагтай золгуулан улмаар 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа батлаж ард олон шашнаа шүтэх эрх, эрх чөлөөг сэргээн хуульчилсан хэдий ч шашин маань номын ёсоор цэцэглэн хөгжих нь учир дутагдалтай байна.

Их хэлмэгдүүлэлтээс өмнө цэцэглэн хөгжиж байсан бурханы шашин эм зурхай, гүрэм засал, хурлын зан үйл (мэгээмийн чого тэргүүтэй олон зан үйлүүд) тэргүүтэй олон салбар шинжлэх ухаан устан үгүй болоод зогсохгүй Бурхан багшаас авахуулаад өөрийн өтгөс дээдэс багш нараар дамжин ирсэн бодитой, нүдэнд эс харагдах лүн ван авшиг, олон жүд дамжлага тасарчээ.

Жишээ нь: Нүннай сахих зан үйл юм. Нүннай сахих зан үйлийн хуралууд дотроос Дарь эхийн нүннай, Маналын нүннай, мөн Шадүвлингийн хийдэд хурдаг байсан. “Цагаан буяны найман чуулган” нэрт Жанрайсигийн нүннайг найм хоног сахидаг байсан, гэх мэт жажүд ёсны бурхадын үүднээс үйлддэг “Нүннай” буюу бясалгал бүтээлийн олон сайхан зан үйлүүд маань тасраад зогсохгүй үлдсэн зарим нь тасархад хүрээд байгаа нь нэгэн нам, үзэл суртлын дор 70 гаруй жил хавчигдаж байсан холбоотой ч цагийн эрхээр тасарсан, мартагдсан бид бүхний оюуны үнэт бүтээлүүдийг сэргээн уламжлуулах, хадгалан хамгаалах зайлшгүй шаардлага бидэнд тавигдсаар байна. Иймийн тулд түүхийн ийм эгзэгтэй цаг мөчид Бурханы Шашнаа тайлбарлан таниулах хийгээд номын ёсоор дэлгэрүүлэн хөгжүүлэх нь лам хувраг бидний эрхэм үүрэг байх ёстой.

Учир иймд Бурханы шашин Монгол оронд маань номын ёсоор дэлгэрэн хөгжих үйлсэд өчүүхэн ч атугай хувь нэмрээ оруулахын үүднээс урьд Шадүвлингийн хийдэд хурдаг байсан “Гарву цогжад” буюу “Цагаан буяны найман чуулган” (нүннай) хурах зан үйлийг судлан шинжлэж, дахин урьдын ёсоор хурах зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлэн энэхүү сэдэвийг сонгон илтгэл бичиж хэлэлцүүлхийг зорьсон юм.

Үүнд:

1. Нүннайн талаарх ерөнхий ойлголт, түүний түүхэн уламжлал, үүсэл гарлыг судлах.
2. Нүннай ямар ямар бурхадын үүднээс сахидаг, сахих онцлог ялгаа, төрөл түүнийг нарийвчлан судлах.
3. Нүнэр найвын үндэслэгч болоод Зан үйлийн зохиогчийн намтар цадигийг нарийвчлан судлах.
4. Нүннайн зан үйлийн бүтэц бүрэлдэхүүн болоод уншлагын дэс дарааллыг шинжлэн судлах.
5. Нүннайг сахихад анхаарах зүйл болоод түүнийг сахисны ач тусыг судлан таниулах.

Эдгээр зорилтуудыг дэвшүүлэн судлахдаа түүхчлэн судлах, харьцуулан судлах судалгааны аргуудыг хэрэглэхийн зэрэгцээ эрдэмтэн багш дээдсийн айлдвар зааврын дагуу сийрүүлэв.

Монгол дахь Буддын шашны олон нийтийн байгууллагуудын нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагааны онцлог

О. Эрдэнэчимэг – Ж. Алтайбаатар

Монголын Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн, Монгол улс

XX зууны эцэс буюу Буддын шашин Монгол Улсад дахин сэргэх болсоноос үүдэн шашны уламжлалт хэлбэрийн байгууллагуудаас бүтэц, удирдлагын арга барил, үйл ажиллагааны онцлогоороо ялгараатай шашны – олон нийтийн байгууллагууд үүсэж төлөвшин үйл ажиллагаа явуулах болсон. Энэхүү байгууллагыг бид сүм хийдийн бус шашны олон нийтийн байгууллага гэж нэрлэн судалж байна.

Энэ байгууллагуудын сүм хийдээс ялгарах гол ялгаа нь түүний үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл нь шашны хурал номын үйл ажиллагаа эрхлэх бус харин түүний үзэл сургаалыг дэмжин түгээн дэлгэрүүлэх, сурталчилахын зэрэгцээ харьцангуй бие даасан үйл ажиллагааг явуулдаг юм.

Өөрөөр хэлбэл хатуу дэг жаягт баригддаггүй, зэрэг дэвийн онцын ялгаа байдаггүй, удирдлагын хувьд мэргэжсэн лам хуврагаасаа илүүтэйгээр нэр хүнд бүхий удирдагчидтай байдгаараа онцлог. Мөн сүм хийдээс хараат бус байдаг ба санхүүгийн хувьд тогтворгүй байдаг сул талтай.

Ийм чиглэлийн байгууллагууд цаашид ч өсөн нэмэгдэх хандлагатай байгаа ба үүний шалтгаан нь сүсэгтнүүд дан ганц сүм хийдийн уламжлалт дэг жаягийн дагуу шашны зан үйл үйлдэхээс гадна шашны номлол, сургаалийн талаар санал бодлоо чөлөөтэй хуваалцах, хамтын буяны үйл үйлдэх зэргээр өөр хоорондоо эвлэлдэн нэгдэж, сүм хийдэд хамтдаа үйлчлэх сайн дурын байгууллага байгуулах санаачилга төрөн гарах болсонтой холбоотой юм.

Ингэхээр сүм хийдийн бус шашны байгууллагууд нь шашин номлох, сургаал айлдахад гол зорилгоо хандуулдаггүй, харин түүнийг сурталчилах, дэлгэрүүлэх, буддын шашны үзэл санаа, сургааль номлолын үндсэн дээр нийгмийн ажлуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд чиглэж байна.

2006 оны гуравдугаар сараас 2013 оны 9 дүгээр сарын хооронд Монгол Улсын, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдсэн 7500 ТББ-аас Буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 48 сүм хийдийн бус шашны олон нийтийн байгууллага байна. Эдгээр байгууллагуудын 90 хувь нь (43) Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Булган аймагт 1, Дорноговь аймагт 1, Хөвсгөл аймагт 1, Өвөрхангай аймагт 2 байгууллага тус тус ажиллаж байна.

Судалгаанаас харахад сүм хийдийн бус шашны байгууллагуудын үйл ажиллагааны нэн тэргүүний зорилт нь: 1. Буддын шашны сургаал номлолоор дамжуулан иргэдийн ёс зүй, ухамсрыг дээшлүүлэх, хүнлэг энэрэнгүй нийгмийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулахад чиглэж байгаа нь (нийт байгууллагын 85 хувь нь) харагдаж байна.

2. Буддын сургаалыг судлах, судар ном орчуулах, туурвих ажил нь хоёр дахь том зорилт болж байна. Судалгаанд хамрагдсан 3 байгууллага тутмын 1 нь (33 хувь нь) буддын сургаал, гүн ухааны ном бүтээлийг туурвих, орчуулах (төвд хэлнээс монгол хэл рүү), олон нийт буюу энгийн иргэдэд зориулан хялбаршуулан ном хэвлүүлэх ажлыг үйл ажиллагааныхаа тэргүүн зорилтын нэг гэж үзжээ.

3. Судалгаанд хамрагдсан нийт байгууллагуудын 22 хувь нь нийгмийн эмзэг бүлэг, орлого багатай иргэд, тэр дундаа өнчин хүүхдүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ганц бие эцгүүдэд өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг ажээ.

4. Буддын шашны сүм хийдийн хувьд чухалд тооцогддог шашны зан үйлийн үйл ажиллагаа сүм хийдийн бус шашны байгууллагуудын хувьд хамгийн бага хувийг эзэлж (4.1 хувь) байна.

Сүм хийдийн бус шашны олон нийтийн байгууллага нь гол төлөв сүсэгтний сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, санхүүгийн тогтвортой их үүсвэргүй байдгаас зохион байгуулалтын хувьд ижил төстэй шашны байгууллага, сүм хийд, олон улсын байгууллага, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах нь түгээмэл байдаг.

Шашны бус олон нийтийн байгууллагууд сүм хийдтэй харьцуулахад иргэд, олон нийтийг хамарсан компани ажил, нөлөөллийн арга хэмжээг илүү идэвхитэй явуулдаг. Тэд буддын шашны сургаал номлолын мөн чанар, уламжлалт ёс заншлын утга учрыг олон нийтэд таниулах, нийгмийн итгэл үнэмшил, ёс суртахууныг дээшлүүлэх, олон нийтийг хамарсан лекц, сургалт зохион байгуулах, хялбаршуулсан нэвтрүүлгүүдийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр түгээж дэлгэрүүлэх замаар хувь хүн, нийгмийн бүлэг, нийгмийн оюун санааны амьдралд эерэг өөрчлөлтийг авчиргахад чиглэж байгаа нь өнөөгийн манай нийгмийн амьдралд чухал ач холбогдолтой.

Энэ төрлийн байгууллага цаашид ч өсөн нэмэгдэх хандлагатай байгаа ба үүний шалтгаан нь сүсэгтнүүд дан ганц сүм хийдийн уламжлалт дэг жаягийн дагуу шашны зан үйл үйлдэхээс гадна шашны номлол, сургаалийн талаар санал бодлоо хуваалцах, хамтын буюу үйл үйлдэх зэргээр өөр хоорондоо эвлэлдэн нэгдэж, сүм хийд төдийгүй нийгэмд хамтдаа үйлчлэх санаачилга төрөн гарах болсноороо давуу талтай.

“Ихэд тонилгогч судар”-ын зан үйл

Чулуунбаганын Эрдэнэ-Уул

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Багшийн Их Сургууль,
Бурханы Соёл Судлалын Хүрээлэн, БНХАУ

“Ихэд тонилгогч судар” бол Монгол, Төвд оронд өргөн дэлгэрсэн их хөлгөний сургаал болно. Сударт номлосон нүгэл хилэнцээ наманчлан арилгах зан үйл нь ардын дунд ихэхэн уламжлагдсан байдаг. Уул судрын нүгэл хилэнцээ наманчлан арилгах зан үйлийн тухай Банчин богд Лувсанбалдан-иш, Чин сүжигт Лувсанноровшарав тэргүүтэн олон эрдэмтний тайлбар зохиол буй. Өгүүлэлд уул судар дахь зан үйлийн номлол болон түүний тайлбар зохиолууд нь ардын дунд хэрхэн нөлөөлж байгааг танилцуулахыг хичээсэн болно.

On the basis of the famous narrative about four meetings of Buddha

Evgeniia SHUBINA

Eötvös Loránd University, Department of Mongolian and Inner Asian Studies, Hungary

Since the 14th century biographies of Buddha began to occur in various genres of the Mongolian literature. In the article I give a philological and analytical evaluation of one of the most popular narrative of Buddha's life where the four meetings of a Bodhisattva are described: the meetings with an old person, a sick person, a dead and a monk. Three sources are taken as a basis: “The twelve deeds of Buddha” by Šes-rab Senge (14th century), index of the Kangxi's Kangyur (18th century), and “Bolor Toli” by Jambadorji (19th century). To understand who adhered to which tradition of Buddha's narrative and what is the primary source in addition the Tibetan interpretation of the “twelve deeds” by Buton Rinchen Drub (14th century) is also analyzed.

Бурханы шашинтай холбогдох эд өлгийн зүйлс

С. ГАНСҮХ

“Мөнхийн урлаг” эртний эдлэлийн галерей, Монгол улс

Миний бие Монголын нүүдэлчдийн биет өвийг цуглуулан 15 жил гаруй хугацааг өнгөрүүлэх явцдаа тэдгээрийн урлан бүтээхийн онцлог, бэлэгдэл, ёс заншил, зан үйл гэх зэргийн онцлог шинж чанарыг судалж ирсэн болно. Урлагийн бүтээлийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, сурталчилан таниулах үүднээс цуглуулгаараа црмог гаргасан.

Миний цуглуулганы ихэнх хувь нь Бурханы шашинтай холбогдолтой эд өлгийн зүйлс зонхилдог. Иймээс өөрийн цуглуулганаас онцгой хийц бүхий эд зүйлсийг онцлон тайлбарлан танилцуулах болно.

Шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст эзэн хаан 8-р Богд Жавзандамба хутагтын дэлгэмэл шүтээн зураг

Болд ШҮР

“Мөнхийн урлаг” эртний эдлэлийн галерей, Монгол улс

Аливаа орны эртний эд өлгийн зүйлс нь тухайн орны туулж ирсэн түүхэн цаг хугацааны баримт, нотолгоо болж өгдөгөөрөө үнэ цэнтэй байдаг. Тиймээс ч биет өвийг үрэгдэж үгүй болохоос сэргийлж хадгалан үр хойчдоо өвлүүлэн үлдээх нь чухал юм. С. Гансүх, бид нарын цуглуулгаа эмхэтгэн 2007 онд “Нүүдэлч монголын сод бүтээлүүдийн дээжээс” номоо монгол, англи хэл дээр гаргасан ба цуглуулганыхаа хэсгээс эрдэмтэн, судлаач сонирхогчдын бүтээлүүдэд хэсэгчлэн гаргаж байсан байдаг. Эртний өв соёлыг цуглуулна гэдэг нь зөвхөн өөртөө дарж хадгалахын учир биш өргөн олондоо таниулах, өөрийн олж мэдсэн зүйлсээ хуваалцах, дотоод гадаадын эрдэмтэн судлаач, оюутнууд, хүүхэд багачууд, сонирхогч нарт гарын авлага болж тэр тусам шинжлэх ухааны эргэлтэнд орж байж өр өгөөж утга учир үр дүнтэй болох нь гарцаагүй юм.

“Мөнхийн урлаг” эртний эдлэлийн галерей маань он цагийн хувьд Хүрэл зэвсгийн соёлын үеэс эхлээд 19-р зууныг хамарч байгаа бол төрөл зүйлийн хувьд ерөнхийд нь ангилж авч үзвэл 6 хэсэгт хувааж үзэж болох юм. Цуглуулганд багтаж байгаа биет өв маань тус бүр өөр өөрийн дахин давтадашгүй онцлогтой үүнд: оюуны өв, урлан бүтээхүйн өв, ардын ахуйн соёл, улиран өнгөрөх он цаг дахь хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил, шашин шүтлэг, ардын аман зохиол гэх мэт маш олон үнэт өвийг өөртэй агуулж байдаг онцлогтой.

Энэ удаа Бурханы шашны эрдэм шинжилгээний хуралтай холбогдуулан тэр цуглуулагнаас онцлон “дэлгэмэл шүтээн зураг” төрөлд багтах “Шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст эзэн хаан 8-р Богд Жавзандамба хутагт”-ын дэлгэмэл зурагын тайлбарыг өөрийн мэдэж авсанд тулгуурлан тайлбарлахыг оролдьё. 8-р Богд монголд Буддын шашин болоод тусгаар тогтнолоо тунхаглахад өөрийн оюун ухаан, сэтгэл зүрхээ зориулсан гавьяатай монголын сүүлчийн хаан, шашин төрийн тэргүүн юм. Энэхүү бүтээлийг орчин үеийн дүрслэх урлагийг үндэслэгч, соён гэгээрүүлэгч, их зураач Марзан хэмээх Балдуугийн Шаравын 20-р зуунд бурханчлан бүтээсэн шүтээн зураг юм.

Монгол дахь Жодын дамжилгын их багш Лувсанбанзар

Ч. ГАНТУЛГА

Тарвалин хийд, Монгол улс

Манай хийдийг анхлан Жодын Их багш Хандын Лувсанбанзар 1989 оны 12-р сарын 22-ны өдөр буюу Шороон могой жилийн өвлийн эхэн сарын зулын 25-нд Баянгол дүүргийн нутаг дэвсгэр, Гэмтэл, согог сэргээн засах клиникийн эмнэлгийн зүүн талд байгуулсан түүхтэй. Тэр сууриндаа удалгүй СХД-ийн нутаг дэвсгэр Баянхошуунд очиж суурьшин, Бакула Ринбүчи багшийг залах үеэр Элчин багш: “Намдолдэчэнлин” хэмээх алдрыг хайрласнаар хийдийнхээ нэрийг өөрчилсөн. Хожим Х. Лувсанбанзар багшийн шавь Т. Ариунболд, Шашны Дээд сургуулийн нэг ангийн лам хуврагууд болон номын шавь нарынхаа хамт 2007 онд БЗД-ийн нутаг дэвсгэр Маахуур толгой дээр шинэ хурал үүсгэн байгуулж, багшаасаа алдар хайрлахыг айлтгасанд багш огтхон ч эргэлзэлгүй “Тарвалин” хэмээн айлдсан бөгөөд Монголын Бурханы шашны Тэргүүн XI Богд багшаас “Тарвалин” хэмээх нэрийн тамгатай бичиг залсан түүхтэй. Бид Бурханы шашны Улааны буюу Нинмава ёсны дэгээр хурлаа хурж, сүсэгтэн олны тус дэмжлэгээр үйл ажиллагаа эрхлээд 10 дахь жилтэйгээ золгож байна.

Дээр цухас дурдсан дамжлагын багшийнхаа тухай өгүүлэхэд “Хэргийн тухайд алдрыг өгүүлвээс” Хандын Лувсанбанзар багш Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу буюу энэ цагийн Дундговь аймгийн Дэрэн сумын нутаг Цант халтар хэмээхүйд 1914 онд мэндэлсэн. Дэлгэрийн чойрын хийдэд анх шавилан сууж буян номын мөрд хөтлөгдсөн, улмаар Жодын ёсыг таалалд барин Баянцагаан сумын бэлийн хийдэд шавилж, Лувсанжав багшаасаа судрын ёсны уншлага, ерөөл, магтаал хийгээд арвис тарни бүгдийг сонсов. Пунцаг зоч багшаасаа гадаад дотоод нууц гурван их тантрын аймгийн авшиг, баатар дагинасын чихний чимэг дээд арвис баригчийн нууц номлолыг хүртжээ. Номын чуулганы хүрдийг машид эргүүлсэн мэргэн гэгээн Дугар багшдаа олонтаа мандал өргөн их ерөөлийг айлтаж, дөрвөн авшгийн нүүр орчуулагч Намхай гожэдийн ван авшиг, их дуусгалын зарлигийн ном бүхнийг сонсон, багшийг шүтэж номын рашаанаар цэнгэсэн.

Тэндээс гурван жил тасралтгүй ууланд суун үхээрийн газар оршиж, оюун судлахуйн хийгээд нямба бүтээлийн ёс алиныг үзүүлэн, дагинас нугууд бээр адистэдлэсэн чадал лугаа төгс егүээр нэгэн болсон буй. Баатарлаг цогт дээд эрдэмт төгс багшийн хамаг амьтны тусад бүтээсэн үйл хийгээд эрдмийн их гуу сангаас хүртсэн хувь төгөлдөр шавь тэдгээрийг тоочиход эцэст үл хүрэх буюу.

Орчин үеийн Монгол орны Бүддагийн шашны зарим тулгамдсан асуудал

А. ГАНЗОРИГ

Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль, Монгол улс

Монгол оронд Бүддагийн шашин дөрөвдөхь удаа дэлгэрч байгаа энэ цаг үед буй болсон тулгамдсан зарим асуудлыг дараах хүрээнд авч үзнэ. Үүнд: Бүддагийн шашны хөгжлийн түүхийг товчлон авч үзэх ба орчин үеийн нөхцөлд Бүддагийн шашныг шинжлэх ухаанчаар хөгжүүлэхийн учир холбогдлыг зарим нэг асуудлын хүрээнд авч үзэж, хэрэгжүүлэх боломжийн талаар судлаачийн хувьд санал дэвшүүлнэ. Бүддагийн шашны гүн ухаан, зан үйл, ойлголтыг сүсэгтэн олонд ойгомжтой тайлбарлах орчин үеийн шаардлага, Бүддагийн шашны ойлголтыг шинжлэх ухааны ололттой холбон, түүнд шинжлэх ухааныг нэвтрүүлэх, Бүддагийн шашны сургаал, номлолыг орчин цагийн монгол хэлнээ орчуулах, хурал номыг монгол хэлээр хурах, тайлбарлах ажлыг өргөжүүлэх боломж. Бүддагийн шашны зан үйлийг мухар сүсгээр бус шинжлэх ухаанчаар тайлбарлахын ач холбогдол, орчин цагийн Монгол Улсад Бүддагийн шашны тархалт болон түгээн дэлгэрүүлэх боломж, Бүддагийн шашны сургаал номлолыг шинжлэх ухааны үндсэн дээр, ойлгомжтой зөв тайлбарлах, тигийн онол, хот мандлын онол зэргийг шинжлэх ухааны салбарт хэрэглэх боломж. Орчин үеийн нөхцөлд Бүддагийн шашны зүтгэлтэн болон сүсэгтнийг соёлжуулах, мухар сүсгээс салгах, тэдэнд зориулсан сургалт зохион байгуулах, Бүддагийн шашны урлахуй ухааны олон зуун жилийн турш буй болсон ололт амжилтыг Дэлхийн бусад үндэстэнд түгээн дэлгэрүүлэх боломжийн талаар санал дэвшүүлнэ. Эдгээр ажлыг хийхэд тулгардаг бэрхшээл тухайлбал, санхүүжлэгийг шийдвэрлэх боломжийн талаар санал гаргана. Орчин үеийн Монгол үндэстний дунд Бүддагийн шашин дэлгэрэхэд орчин үеийн Монголын Бүддагийн шашны төвийн гүйцэтгэсэн үүргийг тоймлон гаргаж, хэтийн төлөвийн талаар санал дэвшүүлнэ.

Desire for the Sacred Places: Research on the Buddhist Practice in Kalmykia

Takehiko INOUE

Japan Society for the Promotion of Science,
Center for Northeast Asian Studies, Tohoku University, Japan

The purpose of this presentation is to explain today's Buddhist practice in Kalmykia, Russian Federation. Kalmyk people have worked hard to restore Buddhism since the perestroika period, like other religious believers in USSR, even though the Buddhist temples in Kalmykia were thoroughly destroyed in 1930s. The last monks – survivors from the suppression – died in the 1980s. The new leader of the Kalmyk sangha – Erdni Ombadykov was so young and he was not familiar with Russia. Therefore, it was not easy to restore Buddhism even after the Dissolution of Soviet Union. Many studies show that there were various troubles in this process.

Now Buddhism in Kalmykia finished the first phase of “the Revival”. This study focuses on the increasing desires for creating the sacred places among the Kalmyk Buddhist followers. Many actors participated in the projects creating the sacred places. The projects are the spaces where various expectations mingle together. The Kalmyk monks hope to enlighten the followers on Buddhism. The government hopes to restore the local community and to strengthen the sense of public spirit among the citizens. The followers hope for their own salvation and happiness, especially from a viewpoint of Religious Individualism. I will clarify their complicated expectations over the increasing sacred places.

This study is based on interviews made between 2011 and 2017 with some actors, including the Kalmyk spiritual leader E. Ombadykov.

Орчин үеийн монголчуудын оршуулга дахь шашны зан үйлийн асуудалд

Enkhbayar JIGMEDDORJ
Garavsuren IDERMAA

Department of history, National University of Mongolia, Mongolia
National University of Mongolia, Mongolia

Presently, Mongolian funeral practices are mostly guided by Buddhist lama, and have been being implemented under the religious theology. However, in modern society issues around traditional, evolving and currently executing funeral rituals of Mongolian funeral practices in the Ulaanbaatar city arising. Therefore, rapidly growing difficulties must be properly resolved through scientific evaluation, not only in capital city, but also for the development on Mongolia.

Due to the increasing urbanization of Mongolian nation, some changes occurring in the social life's and cultures, especially in the funeral practices, forms and ordinances. In the middle of XX century, the special organization was established to coordinate the funeral services and to measures to have funeral practice ordinances were taken.

In 1956 the Bureau of National Service of Ulaanbaatar city (Khuurorshuulahtovchoo (body burying bureau) was founded in order serve the citizens and it had been operating until the middle of 1990. In 1990 after the Democratic revolution, democratic tradition was established in Mongolia, which followed by excessive flow of religion, with some of the changes in funeral practices and ordinances. In 2004, by the Resolution of the Citizens' Representative Meeting of the Capital city and the Decree of the Capital city Mayor the "Ulaanbaatar Buyan" LLC was founded and have been servicing society with modern and advanced equipment, including the religious ordinances.

The presentation is mainly aimed to discuss the funeral services performed in the in west and east buyan complex of the "Ulaanbaatar Buyan" LLC, which is performing majority of the funeral services in the capital.

Орчин үеийн монголчуудын оршуулга дахь шашны зан үйлийн асуудалд

Энхбаярын Жигмэддорж
Гаравсүрэнгийн Идэрмаа

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн тэнхим, Монгол улс
Монгол Улсын Их Сургууль, Монгол улс

Өнөө үед монголчуудын оршуулгын ёс, зан үйл гол төлөв буддын шашны лам нар ард иргэдэд зөвлөгөө өгч, шашны номлолын дагуу хийгдсээр байна. Харин монгол түмний оршуулгын уламжлал, шинэчлэл, үйлдэж буй зан үйл, Улаанбаатар хотын нөхцөлд үүсч буй бэрхшээл, тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлах, зүй зохистой шийдвэрлэх явдал нийслэлийн төдийгүй Монгол улсын хөгжлийн чухал шаардлагын нэг юм.

Орчин үед монголчууд хот суурин газар суурьших явдал нэмэгдсэнтэй холбоотой нийгмийн амьдрал, соёл түүний дотор оршуулгын ёс, хэлбэр, үйлдэх зан үйлд зарим өөрчлөлт орох болжээ. XX зууны дунд үеэс Улаанбаатар хот дахь оршуулгын асуудлыг эрхлэх тусгай байгууллагыг байгуулж, оршуулгын үйлчилгээг журамтай болгох арга хэмжээ авсан байдаг.

Улаанбаатар хотын иргэдэд үйлчлэх товчоо ("Хүүр оршуулах товчоо") 1956 онд байгуулагдаж, 1990-ээд оны дунд хүртэл эл асуудлыг хариуцаж байв. 1990 оны ардчилсан хувьсгалаар Монголд ардчилсан ёс тогтож, хүний шүтэх, бишрэх эрх чөлөөтэй болсоноор шашны олон урсгал нэвтэрч, үүнтэй зэрэгцэн оршуулгын төрөл, хэлбэр, зан үйл ч зарим талаар өөрчлөгдөж байгаа юм. 2004 онд НИТХ-ын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамжаар "Улаанбаатар буян" ХХК байгуулагдаж, орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглан уламжлалт зан үйлтэй хослуулан буяны ажлыг гүйцэтгэж байна.

Энэ илтгэлд Монгол улсын нийслэл хот дахь оршуулгын ёс, зан үйлийн нэлээд хэсгийг хариуцан гүйцэтгэж байгаа "Улаанбаатар буян" ХХК-ны Баруун, зүүн буяны цогцолборт талийгаачийг хэрхэн үдэж буй зан үйл, үйлчилгээний талаар товч өгүүлэхийг зорив.

Монгол уламжлалт бурхны шашин ба Түмэн өлзийт Хийд

Уухан Жамьян

Монгол Улсын Их Сургууль, Философи, шашин судлалын танхим, Монгол улс

Нэг. Өндөр гэгээн Занабазар монголын уламжлалт бурханы шашинд оруулсан хувь нэмэр

Хоёр. Өвөр монголд дэлгэрсэн монгол уншлагын уламжлалууд

2.1. Нэйж тойн хутагт Авидын хуучин монгол уншлага

2.2. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан нь шинэ монгол уншлага

2.3. Монгол уншлага дэлгэрсэн газар орнууд

Гурав. Түмэн өлзийт хийдийн монгол уншлагын уламжлал

3.1. Түмэн өлзийт хийдийн монгол уншлага

3.2. Өдөр болгоны цогчэн хурлын уншлага, Сарын хурал, Жилийн хурал, Монголоор хурахын дэс дараалал

3.3. Монгол номыг унших арван гурван анхаарал

Дүгнэлт

Монголчууд Төвд хэл бичгийг хэдэн зуун жил хэрэглэснээрээ төвдийн шашин соёлын хөгжилд том хувь нэмэр оруулжээ. Гэвч монгол лам сэхээтнүүд төвд хэлийг өргөн хэрэглэх болсноор зуун зууны туршид монгол бичгийн хэрэглээний хүрээ хязгаарлагдаж, хөгжлийн алхац нь зогсонгуйрахад хүрчээ. Тухайн үед монгол лам нар төвд хэлээр ном зохиол туурвидаг байсан учраас өдгөө болоход монголчууд түүнийг ашиглан хэрэглэх тал дээр учир дутагдалтай байгаа бөгөөд эх хэлнээсээ хөндийрөхөд хүргэсэн байна. Бусад үндэстний үг хэл, үсэг бичгийг хэтэрхий эрхэмлэн хэрэглэх нь өөрийн үндэстний үг хэл,

